

АГУУЛГА

МУИС-ийн захирлын мэндчилгээ.....	2
МУИС-ийн эрхэм зорилго, Үнэт зүйлс.....	3
I БҮЛЭГ. БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	
МУИС-ийн танилцуулга.....	4
Бүрэлдэхүүн сургууль	
• Шинжлэх ухааны сургууль.....	5
• Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль.....	5
• Бизнесийн сургууль.....	5
• Хууль зүйн сургууль.....	6
• Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль.....	6
• Орхон сургууль.....	7
• Завхан сургууль.....	7
• Төгсөлтийн дараах сургууль.....	7
Сургалтын нэгдсэн алба.....	8
Мэдээллийн технологийн алба.....	10
II БҮЛЭГ. МУИС-ИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР	
Бакалаврын сургалтын хөтөлбөр.....	11
Магистрын сургалтын хөтөлбөр.....	19
Докторын сургалтын хөтөлбөр.....	21
III БҮЛЭГ. МУИС-ИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ ЯВЦ	
Хичээлийн жилийн календар.....	23
SiSi мэдээллийн систем.....	25
Хичээлд бүртгүүлэх, баталгаажуулах.....	38
Суралцагчийн мэдлэг, чадварын үнэлгээ.....	38
Суралцагч чөлөө авах.....	42
Суралцагч үргэлжлүүлэн суралцах.....	42
Сургуулиас чөлөөлөгдөх.....	42
Төгсөгчдөд тавих шаардлага, хүсэлт гаргах.....	42
Сургалтын үйлчилгээний төлбөр.....	45
Сургуулиас олгох албан бичиг баримт, лавлагаа.....	46
Оюутны хүсэлт, санал гомдлыг хүлээн авах, барагдуулах.....	47
IV БҮЛЭГ. СУРАЛЦАГЧИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР, ҮЙЛЧИЛГЭЭ	
Санхүүгийн дэмжлэг.....	49
Суралцагч солилцооны хөтөлбөр.....	50
Хөдөлмөр эрхлэлт.....	50
МУИС-ийн номын сан.....	50
Дотуур байр.....	52
Эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээ.....	52
Нийгмийн халамж, үйлчилгээ.....	53
Урлаг, соёл, олон нийтийн үйл ажиллагаа.....	53
V БҮЛЭГ. ШААРДЛАГАТАЙ УТАС БОЛОН ХИЧЭЭЛИЙН БАЙР, ӨРӨӨНИЙ ДУГААР	
Мэргэжилтнүүдийн утас, өрөөний дугаар.....	55
Хичээлийн байрны план зураг.....	57

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын Их Сургуульд шинээр элсэн орсон суралцагч та бүхэнд хичээлийн шинэ жилийн баярын мэнд хүргэе!

МУИС-ийн эрдмийн алтан босгоор хамгийн шилдэг, хамгийн авьяастай суралцагч алхан орж, Монгол улсын ирээдүйг цогцлоон бүтээгч-боловсролтой иргэн болон төгсөн гардаг гэдгээр бид бахархдаг билээ.

Монгол улсад өнөөдөр өөрсдийн мэдлэгээр баялаг бүтээдэг, бие даан шийдвэр гаргах чадвартай, өргөн мэдлэг боловсролтой, ёс зүйтэй боловсон хүчин шаардлагатай байна. МУИС-д-хийгдэж буй шинэчлэл нь нийгмийн энэ бодит хэрэгцээг хангахад чиглэсэн, уян хатан бүтэц, таатай орчинг суралцагч танд зориулж бий болгох зорилготой юм.

МУИС нь өнгөрсөн хичээлийн жилд сургалтын хөтөлбөрүүдээ шинэчлэн, сонголтыг илүү өргөн болгож, суралцагчдад хичээл, багш, мэргэжлээ сонгох бололцоог нээж өгсөн шинэ бүтэц зохион байгуулалтанд орлоо. Мөн түүнчлэн суралцах ая тухтай орчин бүрдүүлэхэд зориулан хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлж, суралцагчийн үйлчилгээний нэгжийг шинэчлэн зохион байгууллаа.

Сонголтыг эрхэмлэсэн сургалтын тогтолцоо нь бүх түвшинд өрсөлдөөнийг өрнүүлж, шударга өрсөлдөөн нь чанартай сургалтыг бий болгоно.

Амжилттай сурах нь асуудал шийдэлт, идэвхтэй эрэл хайгуул, тууштай бүтээлч хөдөлмөрийн үр дүн байдаг.

Та бүхний хувьд шинэ хичээлийн жил ирээдүйн их амжилтын эхлэл байна гэдэгт итгэлтэй байна.

МУИС-ийн оюутан та бүхэн Монгол улсын ирээдүйг бүтээнэ.

Хүндэтгэсэн, Р.БАТ-ЭРДЭНЭ

АЛСЫН ХАРАА

Дэлхийн стандартад нийцсэн, Монгол улсын хөгжил дэвшлийн тулгуур болсон үндэсний загвар судалгааны их сургууль байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Байгаль, нийгэм, хүмүүнлэгийн болон технологийн салбарт шинэ мэдлэг бүтээж, түгээн дэлгэрүүлдэг, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал бүхий үндэсний хөгжлийн үзэл баримтлал бүхий үндэсний их сургууль байж, улс орны хөгжилд далайцтай хувь нэмэр оруулна.

УРИА

"Жинхэнэ мэдлэг, хүнлэг ёс, оюуныг дээдэлнэ.

МУИС-ийн ОЮУТАН МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ"

ҮНЭТ ЗҮЙЛС

1. Академик эрх чөлөө
2. Сонголт ба өрсөлдөөн
3. Сайн засаглал
4. Нийгмийн хариуцлага
5. Уламжлал ба шинэчлэл

I БҮЛЭГ. БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

МУИС-ийн ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын ууган их сургууль (МУИС) нь анх 1942 оны 10 дугаар сарын 5-нд Физик, математикийн, Анагаахын, Мал эмнэлэг, зоотехникийн 3 факультеттайгаар хичээл сургалтаа эхэлсэнээс хойш эдүгээ 72 жилийн хугацаанд эх орны хөгжил дэвшилд гар бие оролцогч 70000 гаруй дээд боловсролтой мэргэжилтэн төгсгөн гаргажээ. Мөн МУИС-ийн түүхэн хөгжлийн явцад одоогийн МУБИС, ХААИС, АШУИС, ШУТИС, ХИС, Ховд их сургуулиуд төрөн гарч, Монгол улсын дээд боловсролын систем төлөвшин хөгжихөд үнэтэй хувь нэмрээ оруулсан билээ.

Монгол Улсын Их Сургууль (МУИС) нь бүрэлдэхүүн 5 сургууль, орон нутаг дахь харьяаллын 2 сургууль, үндэсний статустай 3 хүрээлэн, судалгааны бусад нэгжүүдтэй, бакалавр, магистр, докторын түвшний 23.0 мянга орчим суралцагч, 750 гаруй эрдэмтэн багш, 1400 орчим ажилтан, ажилчидтай Монгол улсын эрдэм оюуны томоохон төв юм.

МУИС-ийг сургалтад суурилсан их сургуулиас тогтвортой хөгжлийн үзэл баримтлал бүхий академик мэдлэгийг нийгэм-эдийн засгийн эргэлтэд оруулдаг, хөгжил дэвшилд хувь нэмэрээ оруулдаг судалгааны их сургууль болгон өөрчлөх зорилт тавин ажиллаж байна.

МУИС-ийн БҮТЭЦ



БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ

ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

МУИС-д байгаль, нийгэм, хүмүүнлэгийн суурь шинжлэх ухааны салбаруудын хөгжиж ирсэн уламжлал, эрдмийн чадавхи туршлагад тулгуурлан, дэлхийн тэргүүлэх их сургуулиудын загвар, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн Шинжлэх Ухааны Сургуулийг байгуулсан юм.

Тус сургууль нь суурь шинжлэх ухааны олон чиглэлээр судалгаа, сургалт эрхэлдэг томоохон төв болохын хувьд ирээдүйд судалгааны их сургууль болон хөгжих МУИС-ийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ихээхэн чухал үүрэгтэй. Одоогийн байдлаар тус сургууль шинжлэх ухааны суурь чиглэлүүдээр сургалт, судалгааны ажил эрхлэн явуулж, Байгалийн ухаан, Нийгмийн ухаан, Хүмүүнлэгийн ухаан хэмээх 3 салбар, мэргэжлийн 19 тэнхимд 470 гаруй багш, 90 орчим ажилтан, бакалаврын түвшний 9200 гаруй оюутан, ахисан түвшний 1900 гаруй суралцагчтайгаар үйл ажиллагаа явуулж, 64 хөтөлбөрөөр бакалаврын, 44 хөтөлбөрөөр магистр, докторын сургалт эрхэлж байна. Тус сургуульд Гадаад хэлний сургалтын төв харьяалагддаг.

Байгалийн ухааны салбар: Математик, Физик, Хими, Биологи, Газарзүй, Геологи-геофизик зэрэг мэргэжлийн 6 тэнхимтэй. Шинжлэх ухааны эдгээр чиглэлээр олон улсын хөгжлийн нийтлэг чиг хандлагад нийцсэн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж, бакалаврын болон ахисан түвшний шаталсан сургалт явуулж улс орны хөгжилд далайцтэй хувь нэмэр оруулах, үндэсний сургалт судалгааны төв байх эрхэм зорилготойгоор ажиллаж байна.

Нийгмийн ухааны салбар: антропологи-археологи, боловсрол сэтгэл судлал, эдийн засаг, улс төр судлал, социологи-нийгмийн ажил, сэтгүүл зүй олон нийтийн харилцааны 6 тэнхимтэй. Хөтөлбөрүүд нь уян хатан, сонголт ихтэй, оюутны чадвар чадавхийг нээж хөгжүүлэх, сурах эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг баримталдаг.

Хүмүүнлэгийн ухааны салбар: Философи-шашин судлал, Түүх, Монгол хэл-хэл шинжлэл, Утга зохиол-урлаг судлал, Их Британи-Америк судлал, Европ судлал, Ази судлалын тэнхимүүд болон Гадаад хэлний сургалтын төв харьяалагддаг. Тус сургуульд хэрэгжиж байгаа хөтөлбөрүүд нь уян хатан, оюутны суралцах чадвар, сурах эрх чөлөөг хангахуйц сонголттой байдлаар боловсрогдсон байдаг.

ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ

Хэрэглээний Шинжлэх Ухаан, Инженерчлэлийн Сургууль (ХШУИС) нь МУИС-ийн бүтцийн өөрчлөлтийн дагуу МУИС-ийн хуучин бүрэлдэхүүн болох МТС, МКС, ГГС, ББС, ХХИС, ФЭС гэх мэт салбар сургуулиудаас инженер-технологи, хэрэглээний шинжлэх ухааны чиглэлтэй сургалтын хөтөлбөр, судлаач багш нар, оюутнуудыг нэгтгэн шинэчлэн байгуулагдсан.

Тус сургууль шинжлэх ухааныг техникийн болон нийгмийн өргөн олон салбарт хэрэглэх мэдлэг оюуны үндсэн цөм, тэргүүлэгч байж техник, технологи ба нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шинжлэх ухаанчаар шийдвэрлэх, нийгэмдээ үйлчлэх, улс орны хөгжилд дорвитой хувь нэмрээ оруулах, иргэний өндөр ухамсар, соёлтой шилдэг мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилго тавин ажиллаж байна. Мөн гадаадын тэргүүлэх их дээд сургуулиуд болон эрдмийн зэрэг цолттой, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн профессор багш нараар хичээл заалган судалгаа шинжилгээний ажил дагалдан хийх боломжтой.

БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

Бизнесийн сургууль нь их сургуулийн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд хуучин Эдийн засгийн сургууль, Худалдааны сургуулиудын үндэс суурин дээр байгуулагдсан. Бизнесийн сургуулийг өрнөдийн мэргэжлийн сургуулиудын жишгээр анх удаа тэнхимгүй бүтэцтэй сургууль байгуулах шийдлийг сонгосон.

Тэнхимгүй бүтэц нь сургалтын хөтөлбөрүүд, оюутны болон багшийн сонголтын боломжуудыг өргөжүүлэх, нэгдмэл байдлаар асуудлаа шийдвэрлэх, салбар хоорондын судалгаа ба хамтын ажиллагааг сайжруулах, багшийн зүгээс өөртөө тавих шаардлага нь өндөрсгөх, захиргааны шат дамжлагыг цөөрүүлэх, удирдлагын зардлыг хэмнэх зэрэг олон зорилтуудаас урган гарсан бөгөөд ялангуяа бүтцийн өөрчлөлтийн үед багш нарын хоорондын харилцаанд эерэг үүр амьсгал үүсгэх, багш нар бие биенээсээ харилцан суралцах боломжийг олгох зэрэг давуу талуудтай байна.

Одоогийн Бизнесийн сургууль нь нийт 189 багш ажилтантай, үүнээс үндсэн 91, зөвлөх 10, гэрээт 5 багштай, МСҮТ-ийн 8 багш ажилтан, бусад 75 хичээлийн болон үйлчилгээний ажилтнуудтай, нийт 4900 орчим оюутантай, үүнээс бакалаврын өдрийн хөтөлбөрүүдийн 3146, оройн 341, эчнээ хөтөлбөрүүдийн 192, магистрын 769, доктор 118, МСҮТ-ийн 300 орчим оюутантай бизнесийн сургалт, судалгааны үндэсний томоохон төв юм. Эдгээр суралцагчдад тус сургуульд байршсан санхүү, нягтлан бодох бүртгэл, маркетинг, менежмент, худалдаа, зочлох үйлчилгээ, аялал жуулчлалын 7 үндсэн хөтөлбөрт суралцах болсон билээ.

ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

МУИС-ийн Хууль Зүйн сургууль нь эх орондоо дээд боловсролтой хуульчдыг анх бэлтгэсэн үеийн эрх зүйчдийн эрдмийн өлгий билээ. Эдүгээ тус сургууль нь дээд боловсролтой эрх зүйчдийг бэлтгэх, хууль зүйн шинжлэх ухааны дотоодод төдийгүй гадаадад хүлээн зөвшөөрөгдсөн сургууль болон өсөн бэхжсэн байна.

Хууль зүйн эрдэм судлал, сургалтын талбарт үндэсний тэргүүлэх төв байж, нийгэмд манлайлах чадвартай, хууль, шударга ёсны төлөө үнэнч ажиллах, мэргэжлийн өндөр үр чадвартай, ёс зүйтэй эрх зүйчдийг бэлтгэхэд оршино.

Хууль зүйн сургууль нь эрх зүй, олон улсын эрх зүй хөтөлбөрөөр сургалт явуулдаг мэргэжлийн 5 тэнхим, сургалт судалгааны 4 төв, 46 үндсэн багш (удирдах албан тушаалтныг оролцуулан), гэрээт 11 багш, гадаад (япон, солонгос) 8 багш, нийт 65 багштай сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж байна. Багш нарын 40 гаруй хувь нь гадаадын өндөр хөгжилтэй улсад магистр, докторын зэрэг хамгаалсан. Багш нарын 50 гаруй хувь нь хууль зүйн ухааны болон шинжлэх ухааны докторын зэрэгтэй.

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ

Олон улсын харилцаа, Олон улсын эрхзүй, Олон улсын эдийн засгийн харилцааны чиглэлээр үндэсний боловсон хүчинг гүнзгийрүүлэн бэлтгэж ирсэн. Тус сургууль нь Олон улсын харилцааны чиглэлийн зэрэгцээ Төрийн захиргаа, удирдлагын чиглэлээр үндэсний боловсон хүчин бэлтгэхээр Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль болж өргөжлөө.

Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн үндсэн зорилго бол улам бүр даяаршиж буй өнөө үед олон улсын харилцаа болон Зүүн Азийн бүс нутагт Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, үндэсний эрх ашгийг хамгаалж бататгах, мэдлэгт суурилсан, тогтвортой, идэвхтэй гадаад бодлого хэрэгжүүлэх, гадаад болон үндэсний бодлогын уялдааг хангах, иргэн төвтэй засаглалын тогтолцоог бэхжүүлэхэд оюун санаагаа дайчлан хошуучлан оролцох чадвартай үндэсний шилдэг боловсон хүчин бэлтгэх явдал юм.

ОУХНУС-д өнөөдөр бакалаврын түвшинд 800 гаруй оюутан, 200-аад магистрант, 50 орчим докторантаас гадна ОХУ, БНХАУ, Япон, Солонгос, Вьетнам, Лаос, Украйны 50 орчим оюутан суралцаж байна.

ОРХОН СУРГУУЛЬ

УБИС-ийн харьяа Эрдэнэт хот дахь Гадаад хэлний дээд сургууль нэртэй байгуулагдан Англи хэлний багш мэргэжлээр сургалтын үйл ажиллагаагаа эхэлж 1996 оноос МУИС-ийн Орхон аймаг дахь салбар сургууль болжээ.

Тус сургууль нь 60 гаруй багш, 1500 гаруй оюутан суралцагчидтай сургалтын үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд багшлах боловсон хүчний чадвар, сургалтын тав тухтай орчин зэрэг дээд боловсролын байгууллагад тавигдах шаардлагуудыг хангасан байдлаараа орон нутагт үйл ажиллагаа явуулж буй томоохон сургуулиудын нэгд зүй ёсоор тооцогддог юм.

Орхон сургууль нь Тохилог сургалтын болон сурах орчин бүрдүүлж, чанартай боловсрол түгээх, хувь хүний болон мэргэжлийн дээд жишигт нийцсэн төгсөгчдийг бэлтгэн гаргадаг. Мөнх эрүүл мэнд, эдийн засгийн хөгжил, нийгмийн сайн сайхан байдлыг дэмжиж, улс орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулсаар байна.

ЗАВХАН СУРГУУЛЬ

МУИС-ийн Завхан сургууль нь Худалдааны техникум, ТМС-ээс МУИС-ийн бүрэлдэхүүний сургууль болон өргөжиж өнөөдрийн байдлаар 80-аад багш ажиллагсадтай, 600 гаруй оюутантайгаар сургалтын үйл ажиллагаа явуулж 20 орчим мэргэжлээр 8000 гаруй боловсон хүчнийг бэлтгэн Монгол орны хөдөлмөрийн зах зээлийг хангах үүргээ нэр төртэй биелүүлж байна.

Манай сургууль нь МУИС-ийн сургалтын үйл ажиллагааг баруун бүс нутагт явуулж, Монголын баруун бүсийн аймгуудыг “Бизнесийн удирдлага”-ын мэргэжилтэй боловсон хүчнээр хангахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг боловсролын 2 дахь шатны магадлан итгэмжлэлд орсон Төрийн өмчийн сургууль юм.

Нягтлан бодох бүртгэл, санхүү, банк, маркетинг, худалдаа, менежмент, бичиг хэрэг оффисийн ажилтан, электрон системийн автоматжуулалт хөтөлбөрүүдээр бакалаврын зэрэгтэй боловсон хүчин бэлтгэн гаргадаг.

Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг гүнзгийрүүлэх, үр дүнг нь практикт нэвтрүүлэх, Монгол улсыг бүсчлэн хөгжүүлэх төр засгийн бодлогыг баруун бүс нутагт хэрэгжүүлэхэд чиглэгдсэн сургалт, эрдэм шинжилгээ судалгааны шинэ зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГУУЛЬ

МУИС нь 1991-1992 оны хичээлийн жилд анх удаа магистрын сургалтын хөтөлбөр эхлүүлэн магистрант оюутан элсүүлэн сургаж, 1999-2000 оны хичээлийн жилээс докторын сургалтын хөтөлбөр эхлүүлэн доктор (Ph.D)-ын сургалтанд докторант оюутан элсүүлэн сургаж эхэлсэн байна.

1999 онд Магистр докторын сургалтын алба (МДСА)-ыг албан ёсоор байгуулан ажиллаж 2012 оноос МДСА-ыг Төгсөлтийн дараах сургууль (ТДС) болгон өргөжүүлж үйл ажиллагаагаа явуулж байна.

ТДС нь: Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон сургуулийн удирдлагаас магистр, докторын сургалт, судалгааны үйл ажиллагааны талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг зохих журамд тусгах, Магистр, докторын судалгааны ажлын агуулга, хэлбэр, зохион байгуулалтын асуудлыг сургалтын стандартад нийцүүлэн төлөвлөж, хэрэгжилтэд хяналт тавьж, Судалгааны үйл ажиллагааны хүрээнд магистрант, докторант оюутны эрдэм шинжилгээний ажлын чанар, үр дүнг сайжруулах, сургалтын болон судалгааны ассистантшип (судалгааны сэдэвт ажил, төсөлд оролцуулж цалин урамшуулал олгох) хөтөлбөр хэрэгжүүлнэ.

ТДС-ийн зүгээстүхайн хичээлийн жилд шинээр доктор хамгаалсан болон докторын дараах сургалтад хамрагдсан багш нарын бүрэлдэхүүнтэйгээр МУИС-ийн нийт магистрант, докторант

суралцагчдад зориулан эрдэм шинжилгээний арга зүйн семинарыг зохион байгуулж, семинарын зарлал болон лекцыг МУИС-ийн албан ёсны www.num.edu.mn болон www.graduate.num.edu.mn вэб-д долоо хоног бүрийн даваа гарагт байршуулан долоо хоног бүрийн Лхагва гарагт семинарыг зохион байгуулж хэвшээд 3 дах жилдээ ажиллаж байгаа бөгөөд МУИС-ийн МЭДЭЭ цуврал гарын авлагад мэдээллийг хэвлүүлэн тогтмол түгээдэг.

Мөн МУИС-ийн багш нараас сүүлийн 5-6 жилд гадны өндөр хөгжилтэй орнуудад докторын зэрэг хамгаалсан залуу эрдэмтдийн диссертацийн ажлын чиглэл, гарсан үр дүнгийн талаар мэдээлэл солилцох, докторын ажил хамгаалахад түлхэц болох багш нар хамтран салбар дундын судалгааг хөгжүүлэх, одоо суралцаж буй докторант суралцагчдад сүүлийн үеийн судалгааны арга зүйн талаар мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор NUM-SPEAKER SERIES, МУИС-ийн “ЗАЛУУ эрдэмтдийн индэр” цуврал лекц хөтөлбөрийг хэрэгжүүлэн долоо хоног бүрийн Пүрэв гарагт зохион байгуулан, зарлалыг МУИС-ийн албан ёсны www.num.edu.mn болон www.graduate.num.edu.mn вэб-д гаргаж, лекцийг YouTube хуудсанд бүрэн эхээр байршуулан цаашид уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Төгсөглтийн дараахь сургууль

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 1
МУИС-ийн хичээлийн I байр
Утас:(976-11) 75754400-(1115) /ТДС-ийн захирал/
(976-11) 321983, 75754400-(1145)/ТДС-ийн мэргэжилтэн/
Факс: 976-11-320159
Шуудангийн хаяг: Улаанбаатар-46-А ш/х 6
И-майл хаяг: graduate@num.edu.mn
Вэб хаяг:<http://graduate.num.edu.mn/>

СУРГАЛТЫН НЭГДСЭН АЛБАНЫ ТАНИЛЦУУЛГА

Сургалтын нэгдсэн алба (СНА) нь оюутан таныг МУИС-ийн оюутан болох хүсэлт гаргахаас авахуулаад төгсөх хүртэл үйлчлэхээс гадна төгссөний дараа ч мөн холбоотой ажилладаг “Оюутан төвтэй” нэгж юм. Бид МУИС-ийн суралцагч таныг дээд боловсролын зэрэгтэй иргэн болон төлөвшихөд тань хамгийн ойр ажиллаж МУИС-ийн мянга орчим багш нараар хичээл заалгах сонголтыг хийх боломжоор хангах баг бүрэлдэхүүн юм.

Сургалтын нэгдсэн албаны үндсэн чиг үүрэг

Сургалтын нэгдсэн төв болон салбар алба нь дараах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Үүнд:

- Суралцагч таныг суралцуулж дээд боловсролын зэрэг олгох хөтөлбөрийг МУИС-ийн тэргүүний эрдэмтэн багш нараас бүрдэх хөтөлбөрийн хороод олон талын судалгаа, шинжилгээн дээр үндэслэн боловсруулдаг билээ. СНА нь эдгээр хөтөлбөрийн хороодтой нягт хамтран ажиллаж, батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавьж, үнэлгээ өгдөг.
- Хөтөлбөрийн хүрээнд сургалтын үйл ажиллагаа эрхлэх бөгөөд үүнд элсэлт, оюутны бүртгэл, сургалтын технологи, төгсөлт зэрэг үйл ажиллагааг Монгол улсын хууль, тогтоол, МУИС-ийн дүрэм, Сургалтын журам болон бусад холбогдох бичиг баримтын дагуу явуулна.
- Сургалтын чанарын удирдлагыг хэрэгжүүлж, сургалтын хөтөлбөрийн болон технологийн хэрэгжилтэд мониторинг хийх. Үүний тулд оюутнаас сэтгэл ханамжийн санал асуулга, өргөдөл гомдол хүлээн авах, багш нарын хичээлд хөндлөнгийн мониторинг хийх ажлыг зохион байгуулж хяналт тавина. Мөн суралцагчийн мэдлэг, чадварыг зөвөөр дүгнэх, энэ үйл ажиллагаанд орчин үеийн сургалт, судалгааны техник хэрэгсэл, арга барил ашиглах асуудлыг удирдан зохион байгуулна.

- Сургалтын үйл ажиллагааг дэмжсэн таатай орчин бүрдүүлэх, ном, мэдээллийн хангамжийг сайжруулах бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, сургалтанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, сургалттай холбогдолтой мэдээллийн сан бүрдүүлнэ.

Бид танд Сургалтын нэгдсэн албадаараа дамжуулан дараах үйлчилгээг үзүүлнэ.Үүнд:

1. Суралцагчын суралцах үйл ажиллагааг дэмжихтэй холбогдуулан:
 - Хичээл, мэргэжил сонгоход зөвлөгөө өгч, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа болон бусад шаардлагатай мэдээллээр хангах;
 - Суралцагчын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, хариу өгөх, холбогдох нэгжээр шийдвэрлүүлэх;
 - Суралцагчын суралцах хугацааны холбогдох тодорхойлолт олгох;
 - МУИС-ийн хичээлийн жилийн нээлтийн үйл ажиллагаа, Эрдмийн баяр зэрэг сургалттай холбоотой тэмдэглэлт үйл ажиллагаануудыг зохион байгуулах;
2. Суралцагчын суралцах хугацаанд гарч буй нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч, тусламж дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан:
 - Оюутныг дотуур байранд оруулах;
 - Суралцагчийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах;
 - Суралцагчын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж оюутанд мэдээлэх, хөдөлмөрийн харилцаа, зах зээлд бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулах;
 - Суралцагчын нийгмийн бусад шаардлагатай үйлчилгээнд хамруулах;
 - Оюутны байгууллагуудтай хамтран ажиллах;
 - Суралцагчын соёл, хүмүүжил, урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЛБА

МУИС-ийн Мэдээллийн технологийн алба (МТА) нь анх 2000 онд проф. Ж.Нямжав багшийн санаачлагаар мэдээллийн технологийн төвийн бүтэц зохион байгуулалтаар байгуулагдаж улмаар МУИС-д мэдээллийн технологийн шинэ ололт, амжилтыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд тус төвийг алба болгон 2010 онд өргөжүүлсэн байна.

МТА нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- МУИС-ийн нийт багш, ажилчид, суралцагчдад мэдээллийн систем, сүлжээ, холбооны ашиглалттай холбоотой тулгарсан асуудлыг шийдэхэд туслах, заавар зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах үүрэгтэй **Хэрэглэгчдэд туслах баг**
- МУИС-ийн сургалт удирдлагын мэдээллийн систем болон бусад програм хангамж, системүүдийн найдвартай ажиллагааг хангах, мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлэх, хөгжүүлэх үүрэгтэй **Мэдээллийн системийн хөгжүүлэлтийн баг**
- Сүлжээ болон дотуур утасны найдвартай ажиллагааг хангах, шинэ технологийг нэвтрүүлэх үүрэгтэй **Сүлжээ, холбооны баг**

МТА нь Улаанбаатар хот дахь салбар сургуулийн хичээлийн 8 байр, оюутны 6 байр болон Орхон аймагт байрлах МУИС-ийн салбар сургуулийн хичээлийн байрыг хамарсан хотхоны утастай болон утасгүй сүлжээ, Сургалт удирдлагын SISI мэдээллийн систем, Элсэлтийн систем (burtgel.num.edu.mn), Шилжилтийн систем (shiljilt.num.edu.mn) гэх мэт мэдээллийн системүүд, МУИС-ийн вэб сайт, цахим шуудан (***@num.edu.mn, ***@stud.num.edu.mn), Voice communication (VoIP), Хяналтын камер, Утасгүй сүлжээнд нэвтрэх Hotspot authentication, VPN, оюутанд үйлчлэх ТҮЦ машин зэрэг үйлчилгээгээр хэрэглэгчдийг хангаж байна.

Оюутан та манай албанд дээрх системүүдийн ашиглалт, үйлчилгээтэй холбоотой асуудлаар 77307730-(1153), (1154) утсаар хандаарай.

II БҮЛЭГ. МУИС-ИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Хөтөлбөр нь ерөнхий танилцуулга, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сургалтын арга зүй, суралцах орчин, элсэгчдэд тавих шаардлага, багшид тавих шаардлага, төгсөгчдийн эзэмших үр чадвар, суралцагчийн үнэлгээ, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт, удирдлагын мэдээллийн систем, харилцаа хамтын ажиллагаа болон бусад нэмэлт мэдээллээс бүрдэнэ.

Хөтөлбөрийг бакалаврын түвшинд өдөр, орой, эчнээ хэлбэрээр үндсэн, хавсарга мэргэжил олгох, магистрын түвшинд өдөр, эчнээ хэлбэрээр судалгааны болон мэргэжлийн, докторын түвшинд өдөр, эчнээ, экстернат хэлбэрээр боловсруулна.

МУИС-д зөвхөн хөтөлбөрийн ерөнхий хороогоор батлагдсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Дээд боловсролын Бакалаврын зэрэг олгох хөтөлбөр нь “ерөнхий суурь” (General education), “мэргэжлийн суурь” (Core), “мэргэжлийн” (Major) болон “чөлөөт сонголт” (Free elective) гэсэн бүтэцтэй байна.

Хөтөлбөрийн бүрдэл хэсгийн нэр	Тайлбар
Ерөнхий суурь (General education)-МУИС-ийн шаардлага	Дээд боловсролын үндэс буюу ойлгомжтой ярих, бичих; тоон болон тоон бус мэдээллийг боловсруулах; олон ургальч үзэл баримтлалын учир шалтгааныг таньж мэдэх; бусад мэргэжлийн хүмүүстэй үр дүнтэй хамтарч ажиллах, харилцан суралцах мэдлэг, үр чадварыг эзэмшүүлэх зорилготой заавал болон сонгон суралцах хичээлүүд байна.
Мэргэжлийн суурь (Core)-Бүрэлдэхүүн сургуулийн шаардлага	Хөтөлбөрийн суурь мэдлэг, мэргэжлийн чиглэлийн анхдагч үр чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг өгөх зорилготой заавал болон сонгон судлах хичээлүүд байна.
Мэргэжлийн (Major)	Оюутны суралцах үндсэн мэргэжлийн тодорхой мэдлэг, чадвар, дадлыг олгох, заавал болон сонгон суралцах хичээлүүд байна.
Чөлөөт сонголт (Free elective)	Оюутан хавсарга болон хос мэргэжил эзэмших, магистрын хөтөлбөрийн зарим хичээлүүдийг судлах, их сургуулийн хэмжээнд хүссэн хичээлээ сонгон үзэхэд зориулагдсан хичээлүүд байна. Тухайн хичээл нь залгамж холбоотой бол өмнөх хичээлийг заавал үзсэн байна.

Бакалаврын хөтөлбөрийн багц цагийг дараах байдлаар хуваарилна.

	Бүрэлдэхүүн сургуулиуд			Тайлбар
	ШУС, Орхон сургууль /хүмүүнлэгийн салбарын хөтөлбөр/	ХШУИС, БС, ОУХНУС, Орхон сургууль /бизнесийн хөтөлбөр/ Завхан сургууль	ХЗС	
	Цуглуулах багц цаг			
Ерөнхий суурь	36	30	30	120 багц цаг (ХЗС-ийн хувьд 150 бц) бол бакалаврын зэрэг авахад шаардагдах хамгийн доод хэмжээ
Мэргэжлийн суурь	9	21	37	
Мэргэжлийн	60	54	68	

Чөлөөт сонголт	15	15	15	бөгөөд хөтөлбөрийн шаардлагаас үүдэн нэмэгдэж болно.
НИЙТ	120	120	150	
Хавсарга мэргэжил	30	30	30	Мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдээс бүрдэнэ.
Хос мэргэжил	69	75	105	Мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдээс бүрдэнэ. Хоёр хөтөлбөрт ижил хичээл байвал аль алинд нь багц цагийг дүйцүүлэн тооцно.
Орой, эчнээ	69	75	105	Бакалаврын түвшинд эзэмшсэн мэргэжил болон суралцах мэргэжлээсээ хамааран суралцах багц цагийн хэмжээ өөрчлөгдөж болно.

Бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн хөтөлбөр

№	МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль	Сонгох боломжтой бакалаврын үндсэн мэргэжлийн хөтөлбөр
1	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ (ШУС)	Багш-байгалийн ухааны боловсрол /физик, хими, биологи, газарзүй/, Багш-математикийн боловсрол, Байгаль орчны зайнаас тандан судлал, Биологи, Биологийн нөөц судлал, Биохими, Газар зохион байгуулалт, Газарзүй, Геологи, Геофизик, Математик, Физик, Хими, Хот ба бүс нутгийн төлөвлөлт, Экологи,
1.1.	<i>ШУС-ийн Байгалийн ухааны салбар</i>	Антропологи, Архив судлал Нийгмийн ажил, Социологи, Сэтгүүл зүй, Сэтгэл судлал, Улс төр судлал, Эдийн засаг,
1.2.	<i>ШУС-ийн Нийгмийн ухааны салбар</i>	Археологи, Багш-гадаад хэлний боловсрол, Багш-монгол хэл уран зохиолын боловсрол, Багш-нийгмийн ухааны боловсрол, Гадаад хэлний орчуулга, Олон улс-орон судлал/Араб, Герман, Испани, Итали, Их Британи, Америк, Орос, Польш, Солонгос, Турк, Франц, Хятад, Чех, Япон/ Түүх, Урлаг судлал, Утга зохиол судлал, Философи,Хэл шинжлэл, Хэл-уран зохиол, Шашин судлал,
1.3.	<i>ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбар</i>	Аялал жуулчлал, Бизнесийн удирдлага, Даатгал, Зочлох үйлчилгээ, Маркетинг, Менежмент, Нягтлан бодох бүртгэл, Санхүү-банк, Худалдаа,
2	БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ	Нийтийн удирдлага, Олон улсын харилцаа,
3	ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ	Эрх зүй
4	ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ	Байгаль орчныг хамгаалах технологи, Био-инженерчлэл, Биотехнологи, Компьютерийн сүлжээ, Компьютерийн ухаан, Материал судлал, Мэдээллийн систем, Мэдээллийн технологи, Нано шинжлэх ухаан-инженерчлэл, Ойн үйлдвэрлэлийн техник технологи, Програм хангамж, Статистик, Сэргээгдэх эрчим хүч, Ус судлал, Химийн инженерчлэл, Холбооны технологи, Хүрээлэн буй орчин судлал, Хэрэглээний математик, Хэрэглээний хими, Цаг уур, Цөмийн инженерчлэл, Электрон системийн автоматжуулалт.
5	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ	Багш, гадаад хэлний боловсрол, Гадаад хэлний орчуулга, Нягтлан бодох бүртгэл, Санхүү, банк, Даатгал, Менежмент, Маркетинг,
6	ОРХОН СУРГУУЛЬ	Нягтлан бодох бүртгэл, Санхүү, банк, Даатгал, Менежмент, Маркетинг, Худалдаа, Бичиг хэрэг, оффисийн ажилтан, Электрон системийн автоматжуулалт
7	ЗАВХАН СУРГУУЛЬ	

Ерөнхий суурь хичээл.

МУИС-ийн бакалаврын сургалтад тавигдах суурь шаардлагыг хангахад чиглэсэн, 1. Нийгэм, хүмүүнлэг, байгалийн шинжлэх ухааны суурь мэдлэг, ур чадвар 2. Эзэмшсэн мэдлэг, ур чадвараа амьдралд бүтээлчээр бодитой ашиглах дадал олгох үндсэн зорилго бүхий дээд боловсролын суурь судлагдахуун.

Ерөнхий суурь хичээлийг судалснаар оюутан либерал арт боловсрол буюу нийгмийн идэвхтэй гишүүн байхад зайлшгүй шаардлагатай шүүмжлэлт, бүтээлч, логик сэтгэлгээнд суралцаж, санаачлан хийдэг, рациональ шинжлэх ухаанч шийдвэр гаргадаг, хөрвөдөг, нийгэм, хүмүүнлэг, байгалийн ухааны суурь мэдлэг, ур чадвар эзэмшсэн, их сургуулийн боловсролтой, чадварлаг, ёс зүйтэй иргэн болж хөгжинө.

МУИС-ийн ШУС, ОУХНУС, ХШУИС-ийн нэгдүгээр түвшний оюутан эхний 2 улирал, БС-ийн оюутан эхний 3 улирал Ерөнхий суурийн хичээлүүдийг судална. Хэрэв та БС, Завхан сургууль, Орхон сургуулийн (Хэлний чиглэлээс бусад хөтөлбөр) оюутан бол 36 багц цаг буюу 12 хичээл, ШУС, ОУХНУС, ХШУИС, Орхон сургуулийн (Хэлний хөтөлбөр) оюутан бол 24 багц буюу 8 хичээл судлах болно. Хууль зүйн сургууль нэг хөтөлбөртэй тул тухайн журмын заалт үйлчлэхгүй.

Ерөнхий суурь хичээлийн жагсаалт

2014 оны 07-р сарын 08-ны өдрийн
МУИС-ийн Ерөнхий суурийн хичээлийн хороогоор хэлэлцэгдсэн батлагдсан хувилбар

АГУУУЛГЫН ЧИГЛЭЛ, БАГЦ ЦАГ	№	Санал болгож буй хичээл	Харьяа сургууль	Харьяалах тэнхим	Түвшин
I. Байгалийн ухаан					
I. Байгалийн ухаан 6 багц цаг	1	<i>Хүрэх үр дүн: Байгалийн юмс үзэгдлийн мөн чанар, шинжлэх ухааны үзэл баримтлалыг ойлгож тайлбарлах, мэдээлэлд шинжлэх ухаанчаар хандах, таамаглал дэвшүүлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадвартай болно.</i>			
	1	Математик 1a	ШУС, БУС	Математикийн тэнхим	Нийгмийн ухаан, хүмүүнлэгийн ухааны чиглэл гэх мэт
	2	Математик 1б	ШУС, БУС	Математикийн тэнхим	Байгалийн ухаан, инженер, бизнесийн ангийн оюутнуудад зориулсан
	3	Математик 1в	ШУС, БУС	Математикийн тэнхим	Байгалийн ухаан, математикийн чиглэлээр сурах сонирхолтой оюутнуудад зориулсан
	4	Юмс үзэгдлийн физик үндэс	ШУС, БУС	Физикийн тэнхим	Нийгмийн ухаан, хүмүүнлэгийн ухааны чиглэл гэх мэт
	5	Физик	ШУС, БУС	Физикийн тэнхим	Байгалийн ухаан, инженерийн чиглэл
	6	Физикийн үндэс	ШУС, БУС	Физикийн тэнхим	Физикийн мэргэжлээр суралцах

						оюутнуудад зориулсан	
	7	7	Нийгмийн газарзүй	ШУС, БУС	Газарзүйн тэнхим	Хүмүүнлэг, нийгэм, хууль, эдийн засгийн чиглэлээр сурах сонирхолтой оюутнуудад	
	8	8	Дэлхий Судлалын Үндэс	ШУС, БУС	Газарзүйн тэнхим	Байгалийн ухаан, инженерийн чиглэл	
	9	9	Молекул ба эсийн биологи	ШУС, БУС	Биологийн тэнхим	Хүмүүнлэг, нийгэм, хууль, эдийн засгийн чиглэлээр сурах сонирхолтой оюутнуудад	
	10	10	Организм ба эволюцийн биологи	ШУС, БУС	Биологийн тэнхим	Байгалийн ухаан, инженерийн чиглэл	
	11	11	Экологи ба тогтвортой байдал	ШУС, БУС	Биологийн тэнхим	Нийтлэг	
	12	12	Хими ба амьдрал	ШУС, БУС	Химийн тэнхим	Хүмүүнлэг, нийгэм, хууль, эдийн засгийн чиглэлээр сурах сонирхолтой оюутнуудад	
	13	13	Байгалийг танин мэдэх химийн үндэс	ШУС, БУС	Химийн тэнхим	Байгалийн ухаан, инженерийн чиглэл	
II. Хүмүүнлэгийн ухаан 6 багц цаг	II. Хүмүүнлэгийн ухаан						
	14	<i>Хүрэх үр дүн: Сэтгэлгээний түүхийг танин мэдэх, философи, уран зохиолын бичвэрт дүн шинжилгээ хийх чадвар, урлаг гоо зүйн сэтгэлгээг хөгжүүлэх, ёс зүйн үнэлэмжийг төлөвшүүлэх зорилготой</i>					
		1	Хүний хөгжил, харилцааны ёс зүй (2:1)			Нийтлэг	
		15	2	Эрх зүйн үндэс	ХЗС	Төр, захиргааны эрх зүй, Эрх зүй судлал, Эрүүгийн эрх зүй, Олон улсын эрх зүйн тэнхим	Нийтлэг
		16	3	Хэл шинжлэлийн үндэс	ШУС, ХУС	Монгол хэл хэлшинжлэлийн тэнхим	Нийтлэг
	Европ судлалын тэнхим						
		17	4	Соёл судлал	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим	Нийтлэг
	Ази судлалын тэнхим						
		18	5	Дэлхийн соёл иргэншил	ШУС, ХУС	Түүхийн тэнхим\Ази судлалын тэнхим	Нийтлэг\ Дэлхийн түүх хичээлтэй уялдуулж сонголттой санал болгоно.
Европ судлалын тэнхим							
	19	6	Монгол бичиг 1	ШУС, ХУС	Монгол хэл хэлшинжлэлийн тэнхим	Нийтлэг	

	20	7	Урлагийн боловсрол	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим	Нийтлэг	
	21	8	Уран зохиолын удиртгал	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим	Нийтлэг	
	22	9	Шашин судлалын үндэс	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим	Нийтлэг	
	23	10	Философийн үндэс	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим	Нийтлэг	
	24	11	Монгол соёл иргэншил	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим	Нийтлэг	
	25	12	Хүний эрх	ХЗС	ХЗС	Нийтлэг	
	26	11	Олон улсын харилцааны үндэс ба даяаршил	ОУХНУС	-	Нийтлэг	
III. Нийгмийн ухаан 6 багц цаг	III. Нийгмийн ухаан						
	27	<i>Хүрэх үр дүн: Нийгэм эдийн засаг, засаглал, ослын олон талт байдал, хүн хоорондын харилцаа, зан үйлийг танин мэдэх, бүтээлч сэтгэлгээ, шинжлэх ухаанч хандлагад суралцах болно.</i>					
		1	Макрoэкономиксийн үндэс	ШУС, НУС	Эдийн засгийн тэнхим	Нийтлэг	
		28	2	Микрoэкономиксийн үндэс	ШУС, НУС	Эдийн засгийн тэнхим	Нийтлэг
		29	3	Экономиксын үндэс	ШУС, НУС	Эдийн засгийн тэнхим	Нийтлэг
		30	4	Антропологийн үндэс	ШУС, НУС	Антропологи, архeологийн тэнхим	Нийтлэг
		31	5	Археологийн үндэс	ШУС, НУС	Антропологи, архeологийн тэнхим	Нийтлэг
		32	6	Социологи	ШУС, НУС	Социологи, нийгмийн ажлын тэнхим	Нийтлэг
		33	7	Нийгмийн ажил	ШУС, НУС	Социологи, нийгмийн ажлын тэнхим	Нийтлэг
		34	8	Улс төр судлалын үндэс	ШУС, НУС	Улс төр судлалын тэнхим	Нийтлэг
		35	9	Сэтгэл судлалын үндэс	ШУС, НУС	Боловсрол, сэтгэл судлалын тэнхим	Нийтлэг
		36	10	Ардчиллын боловсрол	ШУС НУС	Улс төр судлалын тэнхим	Нийтлэг
	37	11	Бизнес ба нийгэм	БС		Нийтлэг	
IV. Иргэний боловсрол: БШУЯ-ны шийдвэрийн дагуу Монголын түүх хичээл заавал судлах хичээл юм. 3 багц цаг	IV. Иргэний боловсрол						
	38	<i>Хүрэх үр дүн: Монголын түүх соёл, улс төр, эдийн засаг, эрх зүй, хүний үндсэн эрх, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах, багаар ажиллах үр чадварыг хөгжүүлэх болно.</i>					
		1	Монголын түүх (Ерөнхий)	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг	
		39	2	Монголчууд дэлхийн түүхэнд	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг
		40	3	Монголын түүх: Нүүдэллэхүй ёсон	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг.
		41	4	Монголын түүх: Чингисийн эрин ба Евро-Ази	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг
	42	5	Монголын түүх: Эзэнт гүрний дараах	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг	

		Монголчуудын түүх соёл					
	43	6	Монгол ба улаан хувьсгал	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг	
	44	6	Монголын түүх: Монголын нийгэм орчин цагийн дүр төрхөд шилжсэн нь	ШУС ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг	
Судалгаа шинжилгээний арга зүй 3 багц цаг	V. Судалгаа шинжилгээний арга зүй 3 багц цаг						
	<i>Хүрэх үр дүн: Тоон болон чанарын мэдээ баримтанд шинжилгээ хийж үнэлэх, логик сэтгэлгээ хөгжүүлэх, шалтгаан ур чадварын холбоог тогтоох, процессийг загварчлах, асуудал тодорхойлж сурна.</i>						
		1	Компьютер тооцооллын үндэс		Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхим	Нийтлэг	
		46	2	Мэдээлэл, харилцаа холбооны технологи	ХШУИС	Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхим	Нийтлэг
		47	3	Мэдээллийн технологийн үндэс	ХШУИС	Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхим	Нийтлэг
		48	4	Магадлал, статистикийн удиртгал	ШУС, БУС	Математикийн тэнхим	Нийтлэг
					ХШУИС	Хэрэглээний математикийн тэнхим	
		49	5	Статистикийн үндэс	ШУС, БУС, НУС	Математикийн тэнхим Эдийн засгийн тэнхим	Нийтлэг
		50	6	Элементар логик ба математик хандлага	ШУС, НУС	Математикийн тэнхим	Нийтлэг
		51	7	Логикийн удиртгал	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим	Нийтлэг
		52		Хувь хүний санхүү	БС	БС	Нийтлэг
	53	8	Нийгмийн судалгааны аргууд	ШУС, НУС	Социологи, нийгмийн ажлын тэнхим\Эдийн засгийн тэнхим	Нийтлэг	
VI. Яриа бичгийн ур чадвар 3 багц цаг	VI. Яриа бичгийн ур чадвар						
	<i>Хүрэх үр дүн: Яриа бичгийн өөрийгөө илэрхийлэх ур чадвар, эрдэм шинжилгээний бичгийн ур чадвар эзэмших болно.</i>						
		1	Монгол хэл бичиг, найруулга зүй	ШУС, ХУС	Монгол хэл хэлшинжлэлийн тэнхим	Нийтлэг	
		55	2	Хэл ярианы соёл	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
		56	3	Илтгэх урлаг	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим	Нийтлэг
	57	4	Академик бичих ур чадвар (монгол, англи хэлээр)	ШУС, НУС	\Эдийн засгийн тэнхим, Их британи. Америк судлал	Нийтлэг	
VII. Англи хэл, бусад хэл 6 цаг цаг	VII. Англи хэл, бусад хэл 6 цаг цаг						
	<i>Хүрэх үр дүн: Англи хэл \бусад хэл\-ээр мэргэжлийн эх сурвалжийг ашиглаж чаддаг байх, англи хэлний ярих, сонсох, унших, бичих ур чадварын дундын дээд түвшинг (upper intermediate) хангаж өгнө.</i>						

	1	Ерөнхий англи хэл: (анхан)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг	
59	2	Академик англи хэл- 1 (Анхан дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг	
60	3	Академик англи хэл- 2 (дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг	
61	4	Академик англи хэл- 3 (ахисан дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг	
62	5	Солонгос хэл 1	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг	
63	6	Солонгос хэл 2	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг	
64	7	Япон хэл 1	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг	
65	8	Япон хэл 2	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг	
66	9	Хятад хэл 1	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг	
67	10	Хятад хэл 2	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг	
68	11	Франц хэл 1	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг	
69	12	Франц хэл 2	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг	
70	13	Орос хэл 1	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг	
71	14	Орос хэл 2	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг	
72	15	Герман хэл 1	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг	
73	16	Герман хэл 2	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг	
74	17	Араб хэл	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг	
75	18	Турк хэл	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг	
76	19	Чех хэл	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг	
77	20	Итали хэл	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг	
78	21	Испани хэл	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг	
79	22	Төвд хэл	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим	Нийтлэг	
80	23	Санскрит хэлний үндэс	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим	Нийтлэг	
VIII. Биеийн тамир, эрүүл ахуй 3 багц цаг	VIII. Биеийн тамир, эрүүл ахуй					
	81	<i>Хүрэх үр дүн: Бие бялдраа хөгжүүлэх, эрүүл амьдрах ухаанд суралцах, эрсдэл гамшгийн үед аюулгүй байдлаа хангах, анхан шатны тусламж үзүүлэх чадвар эзэмшүүлж өгнө.</i>				
		1	Хүнс ба эрүүл хооллолт	ШУС, ШУС	Биологийн тэнхим	Нийтлэг
		2	Эрүүл мэндийн сэтгэл судлал	ШУС, НУС	Боловсрол, сэтгэл судлалын тэнхим	Нийтлэг
		3	Эмчилгээний биеийн тамир\Тусгай бүлэг		Биеийн тамирын тэнхим	Эрүүл мэндийн байдлаар огцом хөдөлгөөн хийх хязгаартай оюутнуудад
	4	Ерөнхий биеийн тамир		Биеийн тамирын тэнхим	Нийтлэг	

	85	Биеийн тамир (Волейбол)		Биеийн тамирын тэнхим	
	86	Биеийн тамир (Аэробик)		Биеийн тамирын тэнхим	
	87	Биеийн тамир (Сагсан бөмбөг)		Биеийн тамирын тэнхим	
	88	Биеийн тамир (Усанд сэлэлт)		Биеийн тамирын тэнхим	

Мэргэжлийн хөтөлбөр сонголт

Үндсэн мэргэжлийн хөтөлбөр сонголтыг жил бүрийн 1 болон 6-р сард МУИС-ийн захирлын тушаалаар томилогдсон төв болон салбар комисс зохион байгуулах бөгөөд “Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам” -аар зохицуулна.

Оюутан нэг хичээлийн жилд мэргэжил сонгох тандалтын судалгаанд хоёроос доошгүй удаа оролцож цаашид суралцахаар зорьж буй гурван мэргэжлийн саналыг сиси мэдээллийн системээр өгнө. Эхний тандалтыг оюутан МУИС-д элсэх эрхээ баталгаажуулах бүртгэлийн үед өгнө. Хоёр дахь тандалтыг 12 дугаар сард (бс, орхон, завханы сургуулийн хувьд өөр байж болно) багтаан явуулна.

МУИС-ийн ерөнхий суурийн хичээлээс сонгон судалсны дараа Мэргэжлийн хөтөлбөр сонгох журмын дагуу сурлагын голч дүн, амжилттай судалсан хичээлийн багц цаг, МУИС-д элсэхэд тооцуулсан элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоор жагсааж үндсэн мэргэжлээ сонгоно.

Мэргэжлийн суурь (Бүрэлдэхүүн сургуулийн шаардлага)

Мэргэжлийн суурь хичээлийн багц цагт тухайн бүрэлдэхүүн сургууль өөрийн санал болгож буй хөтөлбөр/хөтөлбөрүүдийн шаардлагатай суурь мэдлэг, мэргэжлийн чиглэлийн анхдагч ур чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг өгөх зорилготой заавал болон сонгон судлах хичээлүүд орно. Мэргэжлийн суурь бүрдэл хэсгийн агуулга, цагийн багтаамжийн талаар бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо санал боловсруулж, Ерөнхий хороонд оруулна. Мэргэжлийн суурь нь ШУС-ийн хувьд байгалийн ухаан, нийгмийн ухаан болон хүмүүнлэгийн ухааны чиглэлээр байж болно.

Мэргэжлийн суурь хичээлийн багц цаг нь ШУС-ийн хувьд 9 багц цаг мэргэжлийн сургуулиудын хувьд 21 цаг байна.

Мэргэжлийн хичээл

Мэргэжлийн хичээлийн багц цагт тухайн мэргэжлийн эзэмшвэл зохих шинжлэх ухааны мэдлэг, шаардагдах ур чадвар, дадлыг олгох заавал болон сонгон судлах хичээлүүд орно. Мэргэжлийн хичээлийг гүнзгийрэн судлах хэлбэрээр тэнхим санал болгож болно.

Үндсэн мэргэжил олгох багц цагт оюутны суралцах үндсэн чиглэл/хөтөлбөрийн шинжлэх ухаан/мэргэжлийн бакалавр зэргийн тодорхой мэдлэг, чадвар, дадлыг заавал болон сонгон суралцах хэлбэрээр эзэмшүүлэх зорилготой бүлэг хичээл багтах бөгөөд ШУС-ийн хувьд 60 багц цаг, мэргэжлийн сургуулийн хувьд 54 багц цаг байна. ХЗС-ийн хувьд Нийтлэг шаардлагад заасан нийт багц цагийн багтаамжтай хувь тэнцүүлэн тогтооно.

Үндсэн мэргэжлийн хичээл нь заавал болон сонгон судлах хичээлээс бүрдэнэ. Оюутан үндсэн мэргэжлийн тодорхой салбараар сонгон суралцах боломжтой байх бөгөөд Үндсэн мэргэжлийн сонгох хичээл нь энэхүү зорилгод нийцсэн, оюутан сонгох боломжоор хангагдсан байна.

Чөлөөт сонголт

Чөлөөт сонголтын зорилго нь оюутан МУИС-д зааж байгаа бүх хичээлээс өөрийн хүсэл, сонирхлын дагуу чөлөөтэй сонгох боломжийг олгоход оршино. Чөлөөт сонголтын багц цаг нь 15 багц

цагаас багагүй байх бөгөөд оюутан энэ цагийг үндсэн мэргэжлийн хүрээнд мэргэших, хавсарга болон хос мэргэжил эзэмших, их сургуулийн хэмжээнд хүссэн хичээлээ сонгон үзэхэд зориулна.

Хавсарга болон Хос мэргэжил

Оюутан суралцаж буй үндсэн мэргэжлийнхээ сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээлийг бүрэн судалж, мэргэжлийн хичээлийн багц цагийн 1/3-ийг амжилттай цуглуулсан, суралцсан хугацааны голч дүн 2.6-аас дээш байх шаардлагыг хангасан тохиолдолд хос болон хавсарга мэргэжлээр суралцах хүсэлт гаргаж болно. Хавсарга болон хос мэргэжлээр сурах хүсэлтээ харьяалагдах сургуулийн сургалтын албанд тухайн хичээлийн жилийн 10 болон 3-р сард багтаан өгнө.

- **Хавсарга мэргэжил** олгох хөтөлбөр нь оюутныг хөдөлмөрийн зах зээлд давуу боломжтой оролцох нөхцлийг бүрдүүлэхэд чиглэх бөгөөд нийт 30 багц цаг /мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээл/-аас багагүй байна. Үндсэн мэргэжлийн зэрэгцээ хавсарга мэргэжил эзэмшиж байгаа оюутан бакалаврын зэрэг авахад шаардагдах нийт багц цаг 130 багагүй байна.
- **Хос мэргэжил** эзэмшихдээ өөрийн сурч буй хөтөлбөрөөс гадна суралцах гэж буй хөтөлбөрийнхөө шаардлагыг хангаж, мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдийг судална. Хос мэргэжил эзэмшиж байгаа оюутан хоёр бакалаврын зэрэг авахад шаардагдах нийт багц цагийн хэмжээ 174 багц цагаас багагүй байна.

Бакалавр, магистр, докторын түвшний зэргэцсэн хөтөлбөр

МУИС-ийн бакалаврын 3-р түвшинг 3.2-оос дээш голчтой дүүргэсэн мэргэжлийн чиглэлээр магистрын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй оюутан холбогдох тэнхим, сургалтын албаны зөвшөөрлөөр магистрын судалгааны арга зүй, мэргэжлийн хичээлүүдээс сонгон судлах боломжтой. Бакалаврын зэрэг авсны дараа тухайн магистрын хөтөлбөрт элсэн орж судалсан хичээлээ тооцуулна. Үүнийг цаашид бакалавр, магистрын зэргэцсэн (integrated) хөтөлбөр гэнэ.

МУИС-ийн Судалгааны магистрын 15-аас дээш багц цагийн хичээлийг амжилттай 3.0-аас дээш голчтой дүүргэсэн тухайн мэргэжил, судалгааны чиглэлээр докторын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй магистрант холбогдох тэнхим, сургалтын албаны зөвшөөрлөөр докторын хичээлүүдээс сонгон судлах боломжтой. Магистрын зэрэг авсны дараа тухайн докторын хөтөлбөрт элсэн орж судалсан хичээлээ тооцуулна. Үүнийг цаашид магистр, докторын зэргэцсэн хөтөлбөр гэнэ.

МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР

МУИС-ийн магистрын хөтөлбөр нь судлаач болон мэргэжлийн магистр гэсэн 2 хэлбэртэй байна. Судалгааны магистр: сургалтын төлөвлөгөө нийт 30 багц цаг байна. Судалгааны магистрын хувьд магистрын судалгааны ажил бичиж, эрдэм шинжилгээний 4 багц цаг биелүүлнэ. Үндсэн хичээлийн хувьд ерөнхий суурь хичээл 3 багц цаг, мэргэжлийн хичээл 6 багц цаг, мэргэшүүлэх 8 багц цаг байна.

Мэргэжлийн магистр: сургалтын төлөвлөгөө нийт 32 багц цаг байна. Мэргэжлийн магистрын хувьд магистрын судалгааны ажил бичихгүй мэргэжлийн дадлага хийж багц цаг биелүүлнэ. Үндсэн хичээлийн хувьд ерөнхий суурь хичээл 4 багц (харилцааны чадвар, гадаад хэл), мэргэжлийн хичээл 12 багц цаг, мэргэшүүлэх 12 багц цаг, мэргэжлийн дадлага 4 багц цаг байна.

Дээд боловсролын магистрын зэрэг олгох хөтөлбөр нь мэргэжлийн суурь (салбар, тэнхим, хөтөлбөрийн шаардлага), мэргэшүүлэх (салбар, тэнхим, хөтөлбөрийн шаардлага), чөлөөт сонголт (тухайн хөтөлбөрийг хариуцсан тэнхим, нэгжээс бусад тэнхим, салбар, их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгох хичээл), удирдагч багшийн удирдлага дор хийх эрдэм шинжилгээний ажил, дадлага, магистрын ажил гэсэн бүтэцтэй байна.

Магистрант нь элссэн эхний улиралд багтаан төгсөлтийн дараах сургуулийн баталсан ганцаарчилсан төлөвлөгөөний үлгэрчилсэн загварын дагуу сургалтын төлөвлөгөө боловсруулж, тэнхмийн эрхлэгч/хөтөлбөрийн удирдагч, бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албаны эрхлэгчээр баталгаажуулна.

Магистрант, докторант нь магистрын ажил, докторын диссертацийн сэдэв, сэдвийн дагуу судалгаа хийх төлөвлөгөөг удирдагчтай зөвшилцөн боловсруулна.

Магистрын хөтөлбөрүүдэд тухайн чиглэлээс өөр бакалаврын боловсрол эзэмшсэн элсэгчдэд зориулсан хөтөлбөр боловсруулж болно. Хөтөлбөрийн нийт багц цаг 15 хүртэл байх бөгөөд тухайн шинжлэх ухааны бакалаврын түвшний мэргэжлийн суурь хичээлүүдээс бүрдэнэ.

Судлаач болон мэргэжлийн магистрын хөтөлбөрийн багц цагийг дараах байдлаар хуваарилна.

Хөтөлбөрийн агуулга	Судалгааны магистр	Мэргэжлийн магистр
Судалгааны арга зүй	3 багц цаг Судалгааны асуудал боловсруулах, таамаглал дэвшүүлэх, харьцуулсан судалгаа анализ хийх, зүй тогтол, харилцан хамаарлыг загварчлах, шинэ санаа гаргах, тоон болон чанарын шинжилгээ судалгаа хийх, дүгнэн боловсруулах, тайлагнах үр чадвар	4 багц цагаас доошгүй, үүнээс 2 багц цагийн Харилцааны чадвар (харилцааны стратеги, бүтцийг ойлгодог, бичгийн, электрон, мультимедиа, график дүрслэлээр болон яриа, бичгээр тайлагнах, хүнтэй харилцах) эзэмшүүлэх хичээл, 2 багц цагийн Мэргэжлийн гадаад хэлний хичээл
Мэргэжлийн хичээл	6 багц цаг	12 багц цаг
Мэргэшүүлэх хичээл	12 багц цагаас доошгүй, үүнээс 3 багц цагийг бусад хөтөлбөр, тэнхим, гадаад хэлний төв, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгоно, 4 багц цагийг магистрын ажилд зориулна	12 багц цаг үүнээс 6 багц цагийг бусад хөтөлбөр, тэнхим, гадаад хэлний төв, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгоно
Эрдэм шинжилгээний ажил	4 багц цаг	Мэргэжлийн дадлага 4 багц цаг (мэргэжлийн шалгалтанд бэлдэх модуль сургалтууд)
Магистрын ажил	5 багц цаг	0
		Мэргэжлийн нэгдсэн шалгалт (Мэргэшсэн нягтлан бодогч, хуульчийн гэх мэт)
Нийт багц цаг	30 багц цаг	32 багц цаг

Магистрант нь нийт судлах багц цагийн 20 багц цагийг судалсаны дараа гадаад хэлний шалгалт өгнө.

Магистрын эрдэм шинжилгээний ажлын багц цаг нь удирдагч багшийн удирдлага дор хичээлийн туслахаар ажиллах, бакалаврын семинарын хичээлд бэлдэх, суралцагчдын хичээлийн явцын болон улирлын шалгалтын материал засах, бакалаврын оюутнуудад хичээлийн зөвлөгөө өгөх, эрдэм шинжилгээний хуралд оролцоход туслах, зөвлөгөө өгөх, удирдагч багшийн удирдлага дор судалгааны туслахаар ажиллаж судалгааны ажлын үр дүнг хөндлөнгийн хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлүүдэд хэвлүүлж цуглуулсан байх шаардлагатай.

Магистрын ажил нь профессор багшийн удирдлага дор магистрант бие даан эрдэм шинжилгээний судалгаа хийж, тэнхимд урьдчилсан байдлаар болон магистрын ажлыг хамгаалуулах комисст хамгаалах судалгааны ажил юм. Бүрэлдэхүүн сургуулийн онцлог, тухайн хөтөлбөрөөр олгох цогц

чадамжийн шаардлагаас хамааран магистрын ажилд патент, биеэ даасан үзэсгэлэн, бизнес төлөвлөгөө, эрх зүйн бодлогын судалгааг оруулж болно.

Салбар дундын хөтөлбөрийн нийт багц цаг 32-36 байх бөгөөд дараах байдлаар хуваарилна.

Хөтөлбөрийн агуулга	Салбар дундын судлаач магистр	Салбар дундын мэргэжлийн магистр
Судалгааны арга зүй	3 багц цаг	Харилцааны чадвар эзэмшүүлэх хичээл 2 багц цаг
Мэргэжлийн хичээл	8 багц цаг	15 багц цаг
Мэргэжлийн гадаад хэл	0	0
Мэргэшүүлэх хичээл	8 багц цаг, үүнээс 3 багц цагийг бусад хөтөлбөр, тэнхим, гадаад хэлний төв, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгоно	15 багц цаг, үүнээс 6 багц цагийг бусад хөтөлбөр, тэнхим, гадаад хэлний төв, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгоно
Эрдэм шинжилгээний ажил	4 багц цаг	Мэргэжлийн дадлага 4 багц цаг
Магистрын ажил	9 багц цаг	
		мэргэжлийн нэгдсэн шалгалт (багц цагт орохгүй)
Нийт багц цаг	32 багц цаг	36 багц цаг

Магистрант нь удирдагч багшаа өөрчлөх хүсэлт гаргавал холбогдох мэргэжлийн тэнхим, хөтөлбөрийн удирдагч, удирдагч профессорын саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

ДОКТОРЫН ХӨТӨЛБӨР

Докторын зэрэг олгох хөтөлбөр нь мэргэжлийн суурь (салбар, тэнхим, хөтөлбөрийн шаардлага), мэргэжлийн заавал (салбар, тэнхим, хөтөлбөрийн шаардлага), мэргэжлийн сонгон судлах (тухайн хөтөлбөрийг хариуцсан тэнхим, нэгжээс бусад тэнхим, салбар, бусад их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгох), удирдагч багшийн удирдлага дор хийх эрдэм шинжилгээний ажил, докторын диссертаци гэсэн бүтэцтэй байна.

Докторын хөтөлбөрийн багц цагийг дараах байдлаар хуваарилна.

Хөтөлбөрийн агуулга	Докторын хөтөлбөр
Мэргэжлийн хичээл	8-9 багц цаг.
Мэргэшүүлэх хичээл	14-15 багц цаг, үүнээс 6 багц цагийг бусад тэнхим, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургуулиудаас сонгоно.
Эрдэм шинжилгээний ажил	12 багц цаг, удирдагч багшийн удирдлага дор 2-3 багц цагийг судалгааны сэдвийн дагуух бакалаврын хичээлийг зааж туслах багшаар ажилласан байх, багшийн судалгааны төсөлд оролцож туслах судлаачаар ажиллаж 3-аас доошгүй багц цаг цуглуулсан байх.
Диссертаци	24 багц цаг
Нийт багц цаг	60 агц цаг

Докторын хөтөлбөрүүдэд тухайн чиглэлээс өөр магистрын боловсрол эзэмшсэн элсэгчдэд зориулсан хөтөлбөр боловсруулж болно. Хөтөлбөрийн нийт багц цаг 15 хүртэл байх бөгөөд тухайн шинжлэх ухааны магистрын түвшний мэргэжлийн суурь хичээлүүдээс тухайн докторантын судлах чиглэл, өмнө эзэмшсэн боловсрол, мэдлэг, туршлагыг харгалзан удирдагч багшийн саналыг үндэслэн хөтөлбөрийн дэд хороо шийдвэрлэнэ.

Докторант нь мэргэжлийн хичээлийн багц цагийг амжилтай судалсаны дараа докторын судалгааны ажлыг эхлүүлэхийн өмнө нэгдсэн шалгалт өгнө. Нэгдсэн шалгалт авах бүрэлдэхүүн, хуваарийг холбогдох тэнхим, хөтөлбөрийн хорооны саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирал батална.

Докторын эрдэм шинжилгээний ажлын багц цагийг удирдагч багшийн удирдлага дор докторант сургалтын туслах ажилтнаар ажиллаж бакалаврын хичээлийн лекц, семинарын хичээл заах, удирдагч багшийн удирдлага дор судалгааны туслахаар ажиллах, удирдагч багштай хамтарч хийсэн судалгааны ажлын үр дүнг Томсон Ройтерс, Скопус зэрэг дэлхийн шинжлэх ухааны мэдээллийн санд бүртгэлтэй болон бусад хөндлөнгийн хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлүүдэд хэвлүүлж цуглуулсан байх шаардлагатай.

Бүрэлдэхүүн сургуулийн онцлогоос хамааран, тухайлбал Хэрэглээний шинжлэх ухааны инженерчлэлийн сургууль, Бизнесийн сургуулийн докторантын эрдэм шинжилгээний ажлын багц цагийн тодорхой хэсгийг хөтөлбөрийн онцлогт нийцүүлэн шинжлэх ухааны парк, инкубатор төв, гарааны компани байгуулсан, өндөр технологи үйлдвэрлэлд нэвтрүүлсэн, олон улсын патент авсан бол эрдэм шинжилгээний ажилд дүйцүүлэн тооцох боломжтой.

Докторын диссертацийн судалгаа нь профессор багшийн удирдлага дор докторант шинжлэх ухааны тодорхой салбарын мэдлэг, практик хэрэглээг хөгжүүлэх зорилтыг бие даан шийдсэн эсвэл улс орны нийгэм, эдийн засагт ач холбогдолтой практик асуудлыг шинжлэх ухааны онол, арга, зүйн зохих түвшинд нотолсон, шийдсэн эрдэм шинжилгээний судалгаа хийж, тэнхим/бүрэлдэхүүн сургуулийн их семинар болон докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаалах судалгааны ажил юм.

Магистр, докторын эрдэм шинжилгээний багц цаг, магистрын судалгааны ажил, докторын диссертацийг тухайн сургалтын хөтөлбөрийн дагуу тооцно.

Докторант нь удирдагч багшаа өөрчлөх хүсэлт гаргавал холбогдох мэргэжлийн тэнхим, хөтөлбөрийн удирдагч, удирдагч профессорын саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

Экстернат хэлбэрээр суралцах докторантын мэргэших хичээлийн 18 хүртлэх багц цагийг бүтээлүүдээр нь дүйцүүлэн тооцож болно. Дүйцүүлэн тооцож болох цагийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын томилсон комисс үнэлж, бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлөөр батлуулна. Тухайн хичээлийг мэдээллийн системд удирдагч багш дээр оноож үсгэн үнэлгээ (CR)-г оруулна. Дүйцүүлэн тооцож болох бүтээлд:

1. Үр дүн нь диссертацийн ажилд орохгүй, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэн нийтлүүлсэн өгүүлэл,
2. Их сургуулийн сурах бичиг,
3. Хэвлүүлсэн монографи,
4. Зохион бүтээсэн багаж төхөөрөмж, тогтоосон стандарт, патент,
5. Байгуулсан эрдэм шинжилгээний лаборатори, эрдэм шинжилгээний музей,
6. Зарим боловсруулалтууд (компьютерийн програм, газрын зураг/карт, хуулийн төсөл, бизнесийн кейс судалгаа албан ёсоор улсын хэмжээнд мөрдөж буй аргачлал, стандарт гэх мэт).

III БҮЛЭГ. МУИС-ИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

СУРГАЛТЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сар	Долоо хоног	Өдөр							Үйл ажиллагаа	Өдөр	
НАМРЫН УЛИРАЛ											
VIII сар		Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня	Шилжилтийн бүртгэл эхлэнэ	VIII/10-VIII/17	
							1	2	Шилжих хүсэлтийн эцэслэн шийдвэрлэнэ	VIII/18-VIII/25	
		3	4	5	6	7	8	9	Элсэх эрх авсан суралцагчийг бүртгэх	VIII/17-VIII/21	
		10	11	12	13	14	15	16	Оюутны дотуур байранд амьдрах суралцагчийн бүртгэл эхлэнэ	VIII/17-VIII/22	
		17	18	19	20	21	22	23	Хичээл сонголт, баталгаажуулалт	VIII/24-VIII/31	
		0	24	25	26	27	28	29	30	Магистр, докторын элсэгчдийн шалгалт	VIII/27-IX/3
			31							Шинэ элсэгчдэд чиглүүлэх сургалт	VIII/25-VIII/31
IX сар		Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня	Хичээлийн шинэ жилийн нээлт	IX/1	
	1		1	2	3	4	5	6	Өмнөх улирлын дүнгийн гомдол шийдвэрлэх	IX/1-IX/30	
	2	7	8	9	10	11	12	13	Бакалаврын эцнээ хөтөлбөрийн элсэлтийн бүртгэл	IX/1-IX/21	
	3	14	15	16	17	18	19	20	Магистр, докторын хичээл сонголт, баталгаажуулалт	IX/4-IX/13	
	4	21	22	23	24	25	26	27	Магистр, докторын намрын улирлын хичээл эхлэх	IX/14	
	5	28	29	30					Магистр, докторын суралцагчдад зориулсан чиглүүлэх сургалт	IX/14-IX/18	
X сар		Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня	Хавсрага, хос мэргэжлээр суралцах хүсэлт гаргах	X сард	
					1	2	3	4	Төгсөх хүсэлт гаргах	X/5-XI/8	
	6	5	6	7	8	9	10	11	Явцын шалгалт	X/26-X/30	
	7	12	13	14	15	16	17	18	Магистр, доктор суралцагчдад зориулсан ЭШ семинар	X/7,14,21, 28	
	8	19	20	21	22	23	24	25	Магистр, докторын суралцагч өвөл төгсөх хүсэлт гаргах	XI/9-XI/14	
	ЯШ	26	27	28	29	30	31				
XI сар		Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня	Хавсрага, хос мэргэжлээр суралцуулах тушаал гарна	XI сар	
								1	Төгсөх оюутны нэрс батлагдана	XI/2-XI/6	
	10	2	3	4	5	6	7	8	Багш дараагийн улиралд заах хичээлийн саналаа өгч баталгаажуу	XI/9-XI/15	
	11	9	10	11	12	13	14	15	Хаврын улиралд судлах хичээлийн тандалт, санал өгнө	XI/23-XII/4	
	12	16	17	18	19	20	21	22	Магистр, доктор суралцагчдад зориулсан ЭШ семинар	XI/4,11,18, 25	
		30									
XII сар		Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня	Хаврын улирлын хичээлийн хуваарь гарна	XI/30-XII/18	
	14		1	2	3	4	5	6	Улирлын шалгалт	XII/21-I/1	
	15	7	8	9	10	11	12	13	Магистр, докторын хаврын улиралд элсэгчдийн бүртгэл	XII/1-I/9	
	16	14	15	16	17	18	19	20	Магистр, доктор суралцагчдад зориулсан ЭШ семинар	XII/2,9,16	
	УШ	21	22	23	24	25	26	27	Магистр, доктор суралцагчдадын ЭШ хурал	XII/7-XII/12	
	УШ	28	29	30	31				Магистрын урьдчилсан хамгаалалт	XII/14-XII/18	
I сар		Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня	Шилжилтийн бүртгэл эхлэнэ	I/10-I/18	
						1	2	3	Шилжих хүсэлтийн эцэслэн шийдвэрлэнэ	I/19-I/25	
	НД	4	5	6	7	8	9	10	Нэгтгэн дүгнэх	I/4-I/8	
	УА	11	12	13	14	15	16	17	Улирлын амралт	I/11-I/31	
	УА	18	19	20	21	22	23	24	Төгсөлтийн баяр	I/11-I/22	
	УА	25	26	27	28	29	30	31	Хаврын улирлын хичээл сонголт, баталгаажуулалт	I/11-I/31	
									Магистрын жинхэнэ хамгаалалт	I/4-I/8	
									Магистр, докторын хаврын улиралд элсэгчдийн шалгалт	I/11-I/16	

ЯШ Явцын шалгалт
 УШ Улирлын шалгалт
 НД Нэгтгэн дүгнэх
 УА Улирлын амралт

СУРГАЛТЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сар	Долоо хоног	Өдөр							Үйл ажиллагаа	Өдөр
ХАВРЫН УЛИРАЛ										
II сар		Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня	Хаврын улирлын хичээл эхлэх	II/1
	1	1	2	3	4	5	6	7	Өмнөх улирлын дүнгийн гомдол шийдвэрлэх	II/1-II/29
	2	8	9	10	11	12	13	14	Магистр, докторын суралцагчдад зориулсан чиглүүлэх сургалт	II/1-II/5
	3	15	16	17	18	19	20	21	Магистр, доктор суралцагчдад зориулсан ЭШ семинар	II/3,10,17,24
	4	22	23	24	25	26	27	28		
	29									
III сар		Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня	Хавсрага, хос мэргэжлээр суралцах хүсэлт гаргах	III сард
	5		1	2	3	4	5	6	Төгсөх хүсэлт гаргах	III/7-IV/8
	6	7	8	9	10	11	12	13	Явцын шалгалт	III/28-VI/01
	7	14	15	16	17	18	19	20	Магистр, докторын суралцагч хавар төгсөх хүсэлт гаргах	III/14-III/19
	8	21	22	23	24	25	26	27	Магистр, доктор суралцагчдад зориулсан ЭШ семинар	III/2,9,16,23,31
	28	29	30	31						
IV сар		Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня	Хавсрага, хос мэргэжлээр суралцуулах тушаал гарна	IV сард
	ЯШ					1	2	3	Багш дараагийн улиралд заах хичээлийн саналаа өгч баталгаажуу	IV/11-IV/15
	10	4	5	6	7	8	9	10	Магистр, докторын оюутнуудын ЭШ хурал	IV/25-IV/30
	11	11	12	13	14	15	16	17	Магистр, доктор суралцагчдад зориулсан ЭШ семинар	IV/6,13,20,27
	12	18	19	20	21	22	23	24		
	13	25	26	27	28	29	30			
V сар		Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня	Намрын улиралд судлах хичээлийн тандалт, санал	IV/25-V/6
	13							1	Магистр, доктор суралцагчдад зориулсан ЭШ семинар	V/4,11
	14	2	3	4	5	6	7	8	Магистрын урьдчилсан хамгаалалт	V/2-V/6
	15	9	10	11	12	13	14	15	Улирлын шалгалт	V/23-V/5
	16	16	17	18	19	20	21	22	Магистрын жинхэнэ хамгаалалт	V/16-V/20
	УШ	23	24	25	26	27	28	29		
	УШ	30	31							
VI сар		Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня	Зуны амралтын үеэр байранд амьдрах суралцагчийн хүсэлтийг а	VI/01-VI/10
				1	2	3	4	5	Зуны амралт эхэлнэ	VI/13
	НД	6	7	8	9	10	11	12	Төгсөлтийн баяр	VI/20
	ЗА	13	14	15	16	17	18	19		
	ЗА	20	21	22	23	24	25	26		
	ЗА	27	28	29	30					
VII сар		Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня	Магистр, докторын элсэгчдийн бүртгэл	VII/15-VIII/27
	ЗА					1	2	3		
	ЗА	4	5	6	7	8	9	10		
	ЗА	11	12	13	14	15	16	17		
	ЗА	18	19	20	21	22	23	24		
	ЗА	25	26	27	28	29	30	31		


ЯШ Явцын шалгалт
 УШ Улирлын шалгалт
 НД Нэгтгэн дүгнэх
 ЗА Зуны амралт

СИСИ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

СиСи систем нь МУИС-ийн сургалт үйл ажиллагаанд хэрэглэдэг систем юм. Энэхүү системийн зорилго нь МУИС-ийн сургалт, удирдлага, зохион байгуулалттай холбоотой үйл ажиллагааг хөнгөвчлөх, чанаржуулах, шуурхай, найдвартай, ил тод, хяналттай болгох явдал юм. Энэхүү системийг МУИС-ийн салбар сургуулиудын багш ажилтан, оюутан болон удирдлагууд хэрэглэх ба систем нь МУИС-ийн хүрээнд хэрэглэгддэг системүүд болон бусад гадны системүүдтэй хамтарч ажиллана.

СиСи систем нь вэбд суурилсан, монгол ба англи хэл дээр ашиглах боломжтой бөгөөд диплом, дипломын хавсралтыг англи, кирилл, монгол бичгээр хэвлэхтэй холбоотойгоор монгол бичгийг дэмжинэ.

Элсэлтээс төгсөлт хүртэлх сургалтын бүхий л үйл ажилгаа уг системээр дамжиж явагдана.



1. ТУСЛАМЖ

1.1 Нэвтрэх эрх авах

SiSi системийн хэрэглэгч бүр системд **нэвтрэх нэр, нууц үгтэй** байх ба нэвтрэх нэр МУИС-ийн хэмжээнд давтагдахгүй оюутны хувийн дугаар байна.



Оюутан та нэвтрэх нэр буюу хувийн дугаараа өөрийн сургуулийн сургалтын албаны ажилтнаас авна уу.

Оюутны дугаар нь элссэн он, суралцаж буй түвшин, төрөл, салбар сургууль гэх мэт мэдээллийг агуулдаг. Жишээ нь: Оюутны дугаар 10B1LAW0000 бол

- 10 - 2010 оны элсэлт
- B - Бакалавр
- 1 - Өдрийн анги

- LAW- Хууль зүйн сургууль
- 0000 - давтагдахгүй дугааргах мэт.

Нэвтрэх нууц үг нь оюутны төрсөн он сар өдрөөр үүсдэг. Жишээ нь: 1990 оны 1-р сарын 1нд төрсөн бол таны нууц үг 19900101 гэж үүсэх болно.



Хэрэв та системд нэвтэрч чадахгүй бол төрсөн он сар өдрийн мэдээлэл системд зөв бүртгэгдсэн эсэхийг сургалтын албаны ажилтан хандаж шалгуулна уу.

1.2 Нууц үг солих

Нууц үгээ солихдоо СиСи нүүр хуудасны дээд хэсэгт байрлах тохиргооны цэснээс **Нууц үг солих** цэсийг сонгоно уу. Гарч ирэх хэсэгт өөрийн хуучин нууц үг болон шинэ нууц үгээ оруулан **Өөрчлөх** товчин дээр дарна.

The image shows a user interface for changing a password. On the left, a dropdown menu is open, showing options: 'Хувийн мэдээлэл', 'Хувийн мэдээлэл засварлах', 'Хамгаалалт', 'Нууц үг солих' (highlighted), 'Хамгаалалт', and 'Гарах'. A blue arrow labeled 'Нууц үг солих' points to the right. On the right, a form titled 'Нууц үг өөрчлөх' (Change Password) is shown. It has three input fields: 'Хуучин нууц үг' (Current password), 'Шинэ нууц үг' (New password), and 'Шинэ нууц үг давт' (Repeat new password). A red button labeled 'Өөрчлөх' (Change) is at the bottom.

1.3 Нууц үг мартсан бол

Нэвтрэх хэсэгт байрлах холбоосыг ашиглаж системд бүртгүүлсэн майл хаягаараа шинэ нууц үг авах боломжтой.

The image shows a login page for 'Мэдээллийн систем SISI 4.0'. It has fields for username, password, and a verification code. A red box highlights the link 'Нууц үгээ мартсан уу? / Forgot Password?'. A blue arrow labeled 'Нууц үг сэргээх' (Reset Password) points to the right. On the right, a form for password recovery is shown. It has two input fields: 'Хэрэглэгчийн нэр:' (Username) and 'E-mail хаяг:' (Email). A button labeled 'Илгээх' (Send) is at the bottom.

Үүний тулд та э-майл хаягаа анх оюутан болж системд бүртгүүлэхдээ зөв бүртгүүлсэн байх хэрэгтэй. Мөн сургалтын албаны ажилтандаа хандаж мэдээллээ өөрчлүүлэх, мөн өөрийн хувийн мэдээлэл засварлах хэсгээр өөрчилж болно. Мөн та нууц үгээ мартсан бол сургалтын албаны ажилтандаа хандаж нууц үгээ солиулж авах боломжтой.

1.4 Хэл сонгох

СиСи системийг Монгол, Англи хэл дээр ашиглах боломжтой. СиСи нүүр хуудасны дээр байрлах **EN/MN** холбоосоор хэлээ солих бөгөөд ингэснээр оюутан та дүнгийн тодорхойлолт, хичээлийн мэдээллийг Монгол, Англи хэлээр авах боломжтой.

2. ЕРӨНХИЙ

2.1 Дүнгийн мэдээлэл үзэх

Дүнгийн мэдээлэл нь оюутны сурлагын чанарыг улирал бүрийн, мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнгээр тодорхойлсон баримт байна.

Оюутан та өөрийн эрхийн үндсэн цэсний *Дүнгийн мэдээлэл* хэсгээс нийт болон тодорхой улирал хооронд суралцсан хугацааны дүнгийн мэдээллийг харах болон хэвлэх боломжтой. Тодорхой улирал хоорондох дүнгийн мэдээллээ харах болон хэвлэхдээ хичээлийн жил болон улирлаа оруулан харгалзах товчин дээр дарснаар дүнгийн мэдээлэл гарч ирэх болно.

Дүнгийн мэдээлэл

Хичээлийн жил 2012
Намрын улирал
2012
Намрын улирал
>>

Монгол Улсын Их Сургууль

Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль

2012 оны 9 сарын 1-ны өдрийн 449 тоот тушаалаар "Электроник, автоматик" (Бакалавр, Өдрийн сургалт) хөтөлбөрт элсэн орсон **Овог** овогтой **Нэр**-ын дүнгийн мэдээлэл

ИНДЕКС	ХИЧЭЭЛ	БЦ	ОНОО	ДҮН	ИНДЕКС	ХИЧЭЭЛ	БЦ	ОНОО	ДҮН
2012 Намар	ENGL100 Англи хэл-1	3	83	В-	2013 Хавар	ENGL100 Англи хэл-2	3	92	А-
	SPRT100 Биеийн тамир I	1.5	100	А		SPRT100 Биеийн тамир II	1.5	97	А
	FNDP100 Гамшигаас хамгаалах менежментийн үндэс	1	90	А-		EMAT200 Дифференциал тэгшитгэл	4	100	А
	EPHY101 Механик ба молекулын физик	3	92	А-		ELEC105 Мэргэжлийн дадлага	1	96	А
	COMP100 Мэдээллийн технологи, мэдээллийн систем	3	80	В-		EPHY201 Оптик, квант физик	3	96	А
	ALGE101 Шугаман алгебр, Вектор анализ (Инженерийн математик-1)	4	88	В		CSSW101 Програмчлалын үндэс	3	78	С
	ELEC101 Электроникийн үндэс	3	82	В-		EPHY102 Цахилгаан ба соронзон	3	86	В
			18.5	86.6				18.5	91.8
			Улирлын голч дүн 3.1					Улирлын голч дүн 3.5	

Судалсан багц : **70.0** Голч оноо :

Цуглуулсан багц цаг : **67.0** Голч дүн :

Сургалтын алба

Таны тухайн улиралд судалж буй хичээлийн дүнг багш шалгалтын хугацаанд системд оруулснаар таны дүнгийн мэдээлэлд орж ирнэ. Хэрвээ багш таны дүнг буруу оруулсан тохиолдолд шалгалтын хугацаанд засах боломжтой. Хэрвээ шалгалтын хугацаа дууссан тохиолдолд багш таны дүнг засвал энэ нь засварлагдсан дүн болох бөгөөд энэ дүнг СА-ны эрхлэгч зөвшөөрсөн тохиолдолд таны жинхэнэ дүн болно.



Шалгалтын хугацаа гэдэг нь хичээлийн эцсийн шалгалтыг авах хугацаа юм. Багш энэ хугацаанаас эхлэн ажлын 5 хоногт дүн оруулах, засварлах эрхтэй.

2.2 Хичээлийн хуваарь

Оюутан та өөрийн эрхийн үндсэн цэсний *Хуваарь -> Хичээлийн* хэсэг мөн үндсэн нүүрний дээд хэсэгт байрлах *Хичээлийн хуваарь* хэсгээс өөрийн хичээлийн хуваарийг тухайн нэг өдрөөр болон 7 хоногоор харахаас гадна МУИС-ийн салбар сургууль тус бүрийн бүх түвшний хичээлийн хуваарийг

хичээл, багш болон өрөө хэлбэрээр харах боломжтой. Мөн энэ хэсгээс тухайн хичээлийг орж байгаа багшийн мэдээлэл, өрөөний мэдээлэл болон хичээлийн мэдээллийг харах боломжтой юм.

Өөрийн хичээлийн хуваарийг харахдаа хугацаагаа сонгон **Өөрийн хуваарь** хэсгийг сонгох ба 7 хоногоор харах бол **7 хоногоор** хэсгийг сонгоно. МУИС-ийн салбар сургуулиудын хичээлийн хуваарийг харахдаа салбар сургуулиа сонгон хичээл, багш болон өрөө хэлбэрүүдийн аль хэлбэрээр харахаа зааж өгнө.

The screenshot shows the 'Хуваарь' (Schedule) menu with 'Хичээлийн' (Class) selected. Below it is a screenshot of the 'Бизнесийн сургууль (МУИС, Бс)' (Business School) interface. The interface includes a dropdown for 'Бизнесийн сургууль (МУИС, Бс)', tabs for 'Хичээлээр', 'Багшаар', 'Өрөөгөөр', and '7 хоногоор', and a checked checkbox for 'Өөрийн хуваарь'. Below the tabs are navigation arrows and a dropdown for 'Бүгд - Бакалавр, Магистр, Доктор ...'. The main content shows '2014/2 3-н өдрийн хичээлийн хуваарь' (2014/2 3-day class schedule) and a table with columns for 'Нэрс' (Names) and time slots from 9:00 to 23:50. The table shows a class at 11:25-12:10 in room 115, taught by 'Өсөхбаатар, Д'.

2.3 Шалгалтын хуваарь


Шалгалтын хуваарь нь оюутан таны тухайн улиралд судалж буй хичээлийн эцсийн шалгалтыг авах хуваарь бөгөөд энэ хуваарийг салбар сургалтын албанаас оруулж өгнө. Шалгалтын хуваарийг системээр хийснээр оюутан таны судалж буй хичээлүүдийн эцсийн шалгалт давхцах асуудал гарахгүй бөгөөд өөрийн шалгалтын хуваарийг системээс хялбараар харах боломжтой юм. Оюутан та өөрийн эрхийн үндсэн цэсний **Хуваарь-> Шалгалтын** хэсгээс өөрийн шалгалтын хуваарийг харах боломжтой.

The screenshot shows the 'Хуваарь' (Schedule) menu with 'Шалгалтын' (Exam) selected. Below it is a screenshot of the '2014-2014 оны хичээлийн жилийн хаврын улирал' (2014-2014 academic year winter semester) exam schedule table. The table has columns for 'Огноо' (Date), 'Хичээл' (Class), 'Цаг' (Time), 'Өрөө' (Room), 'Шалгалт авах багш' (Exam teacher), and 'Тайлбар' (Remarks). The table shows two exam entries: one on 2014/05/29 for 'Телехолбооны үндэс ИТСМ351-3.0 кр' in room 114, and another on 2014/05/30 for 'Объект хандлагат програмчлал CSSW223-3.0 кр' in room 116. A note at the bottom states: 'Санамж: Хэрэв таны судалж буй зарим хичээлийн шалгалтын хуваарь жагсаалтанд байхгүй бол СА-наас лавлах буюу СА-ны мэдээллийн самбараас харж нягтална уу!' (Note: If some of the exam schedules of the classes you are studying are not in the list, please check with the SA or the SA's information bulletin.)

2.4 Багш ажилчдын мэдээлэл

Оюутан та өөрийн эрхийн үндсэн цэсний *Багш ажилчид* хэсгээс МУИС-ийн бүх багш, ажилчдын мэдээллийг харах боломжтой. Та МУИС-ийн бүрэлдэхүүн нэгжээс сонгоход тухайн нэгжийн багш, ажилчид гарч ирэх бөгөөд дэлгэрэнгүй танилцуулгатай танилцаж болно.

2.5 Хөтөлбөр



Хөтөлбөр хэсэгт хичээлийн уялдаа болон сургалтын төлөвлөгөө байна. Хичээлийн уялдаа хэсэгт тухайн төлөвлөгөөний хичээл хоорондын уялдаа залгамж холбоо хичээлийн индекс болон кредитийн мэдээлэл дэлгэрэнгүй харагдана.

ХИЧЭЭЛИЙН УЯЛДАА ХОЛБОО

Хичээлийн нэр дээр дарснаар тухайн хичээлийн дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.

ШУС-ийн байгалийн ухааны салбарын ерөнхий суурь хөтөлбөр (Бакалаврын Өдрийн сургалт - -)

Сургалтын төлөвлөгөө: 2014

Хичээлүүд

- Академик англи хэл: Бичих дадал-2 (дунд) (ENGL106 - 1кр)
- Академик англи хэл: Бичих дадал-3 (ахисан дунд) (ENGL111 - 1кр)
- Академик англи хэл: Унших дадал-2 (дунд) (ENGL107 - 1кр)
- Академик англи хэл: Унших дадал-3 (ахисан дунд) (ENGL109 - 1кр)
- Академик англи хэл: Харилцах дадал-2 (дунд) (ENGL108 - 1кр)
- Академик англи хэл: Харилцах дадал-3 (ахисан дунд) (ENGL110 - 1кр)
- Академик англи хэл-Бичих дадал-1 (Анхан дунд) (ENGL104 - 1кр)
- Академик англи хэл-Унших дадал-1 (Анхан дунд) (ENGL103 - 1кр)
- Академик англи хэл-Харилцах дадал-1(Анхан дунд) (ENGL105 - 1кр)
- Академик бичих ур чадвар (монгол, англи хэлээр) (Ерөнхий суурь) (CULT104 - 3кр)
- Англи хэл: Бичих дадал (анхан) (ENGL102 - 1кр)
- Англи хэл: Харилцах дадал(анхан) (ENGL101 - 1кр)
- Антроплогийн үндэс (Ерөнхий суурь) (ANTH100 - 3кр)
- Араб хэл (Ерөнхий суурь) (ARAB100 - 3кр)
- Ардчиллын боловсрол (Ерөнхий суурь) (POLI101 - 3кр)
- Археологийн үндэс (Ерөнхий суурь) (ANTH101 - 3кр)
- Ахисан түвшний бичих дадал (Ерөнхий суурь) (ENGL112 - 2кр)
- Ахисан түвшний яриа (Ерөнхий суурь) (ENGL113 - 2кр)
- Байгалийг танин мэдэх химийн үндэс (Ерөнхий суурь) (CHEM101 - 3кр)
- Биеийн тамир (Ерөнхий суурь) (SPRT100 - 3кр)
- Бизнес ба нийгэм (MGMT130 - 3кр)
- Герман хэл 1 (Ерөнхий суурь) (GERM100 - 3кр)
- Герман хэл 2 (Ерөнхий суурь) (GERM101 - 3кр)
- Дэлхий Судлалын Үндэс (Ерөнхий суурь) (GEOG101 - 3кр)
- Дэлхийн соёл иргэншил (Ерөнхий суурь) (HIST100 - 3кр)
- Ерөнхий англи хэл: Унших дадал (ENGL100 - 1кр)
- Илтгэх урлаг (Ерөнхий суурь) (CULT103 - 3кр)
- Испани хэл (Ерөнхий суурь) (SPAN100 - 3кр)

Сургалтын төлөвлөгөө хэсэгт тухайн оюутан өөрийн сурч буй төлөвлөгөөгөө харах боломжтой. Сурч буй төлөвлөгөөгөө хянаж хичээлээ судалсан судлаагүй гэсэн мэдээллээ хянах юм.

ТАНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хичээлийн нэр дээр дарснаар тухайн хичээлийн дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.

А. Ерөнхий суурь хичээл - (36.0 багц цаг)

А1. Байгалийн ухаан - (6.0 багц цаг)

1	PHYS100	3 бц	Юмс үзэгдлийн физик үндэс (Ерөнхий суурь)	Судлаагүй
2	PHYS102	3 бц	Физикийн үндэс (Ерөнхий суурь)	Судлаагүй
3	GEOG100	3 бц	Нийгмийн газарзүй (Ерөнхий суурь)	Судлаагүй
4	GEOG101	3 бц	Дэлхий Судлалын Үндэс (Ерөнхий суурь)	Судлаагүй
5	BIOL100	3 бц	Молекул ба эсийн биологи (Ерөнхий суурь)	Судлаагүй
6	BIOL101	3 бц	Организм ба эволюцийн биологи (Ерөнхий суурь)	Судлаагүй
7	BIOL102	3 бц	Экологи ба тогтвортой байдал (Ерөнхий суурь)	Судалсан
8	CHEM100	3 бц	Хими ба амьдрал (Ерөнхий суурь)	Судалсан
9	CHEM101	3 бц	Байгалийг танин мэдэх химийн үндэс (Ерөнхий суурь)	Судлаагүй
10	PHYS101	3 бц	Физик (Ерөнхий суурь)	Судлаагүй
11	MATH100	3 бц	Математик 1а (Ерөнхий суурь)	Судлаагүй
12	MATH101	3 бц	Математик 1б (Ерөнхий суурь)	Судлаагүй
13	MATH102	3 бц	Математик 1в (Ерөнхий суурь)	Судлаагүй
Нийт 39 бц				
Судалсан багц цаг 6 бц				

Төлөвлөгөөний биелэлт
/Дутуу багц цагийг заавал гүйцээн судлах/

#	Бүлэг	Судлах ёстой багц цаг	Цуглуулсан багц цаг	Судалж байгаа багц цаг	Дутуу багц цаг
1	А. Ерөнхий суурь хичээл	36.0	24	0.0	12
1.1	А1. Байгалийн ухаан	6.0	6.0	0.0	0
1.2	А2. Хүмүүнлэгийн ухаан	6.0	6.0	0.0	0
1.3	А3. Нийгмийн ухаан	6.0	6.0	0.0	0
1.4	А4. Иргэний боловсрол	3.0	0.0	0.0	3
1.5	А5. Судалгаа шинжилгээний арга зүй	3.0	0.0	0.0	3
1.6	А6. Яриа бичгийн ур чадвар	3.0	0.0	0.0	3
1.7	А7. Англи хэл, бусад хэл	6.0	3.0	0.0	3
1.8	А8. Биелын тамир, эрүүл ахуй	3.0	3.0	0.0	0
Нийт		36	24	0	12

2.6 Оюутны цахим үнэмлэх

Оюутан та салбар сургуулийн сургалтын албаны ажилтандаа хувийн болон элсэлтийн мэдээлэл, цээж зургаа өгсөнөөр сургалтын албаны ажилтан таны мэдээлэл, зургийг системд бүртгэж оюутны үнэмлэхийг захиална. Цахим үнэмлэх бүр дахин давтагдахгүй нууц дугаартай байх бөгөөд таны үнэмлэхний дугаар системд нэвтрэх хэрэглэгчийн нэр байна. Таны цахим үнэмлэх хэвлэгдэн, бүртгэгдсэн бол системээс мэдэгдэх бөгөөд та сургуулийнхаа сургалтын албаны ажилтнаас аваарай. Та үндсэн цэсний **Оюутны цахим үнэмлэх** хэсгээс цахим үнэмлэх хэвлэгдсэн эсэх мөн бусад шаардлагатай мэдээллийг авах болно.

2.7 OCW нээлттэй хичээл

OCW нь Open Course Ware үгний товчлол бөгөөд оюутан та МУИС-ийн бүх багш нарын үүсгэсэн нээлттэй хичээлийг эндээс үзэх боломжтой юм. OCW нээлттэй хичээлийг үзэхдээ <http://sisi.num.edu.mn/ocw> хаягаар эсвэл системийн нүүр хуудасны дээд хэсэгт байрлах **OCW** хэсгийг сонгох ба энэ нь OCW нээлттэй хичээлийг үзэх хэсэг рүү үсрэх болно. Гарч ирэх хэсгээс аль сургуулийн аль тэнхмийн ямар хичээлийг үзэх гэж байгаагаа сонгоно.

Монгол Улсын Их Сургууль OCW

Нүүр | OCW тухай | Бидэнтэй харилцах

Unlocking Knowledge, Empowering Minds. Free lecture notes, exams, and videos from NUM. No registration required.

Монгол Улсын Их Сургууль

Хууль зүйн сургууль

- Эрх зүй судлалын тэнхим (0)
- Төр, захиргааны эрх зүйн тэнхим (0)
- Иргэний эрх зүйн тэнхим (0)
- Эрүүгийн эрх зүйн тэнхим (0)

Бизнесийн сургууль / 9 /

Олон улсын валют, санхүү, эзэлийн харилцаа (FINA301 - 2 кр.)

Банкны нягтлан бодох бүртгэл (FINA116 - 3 кр.)

2.8 Онлайн тестийн систем

Оюутан та тухайн улиралд судалж буй хичээлийн шалгалтыг онлайн аар тест хэлбэрээр өгөх боломжтой. Онлайн аар авах шалгалтын асуулт, хариулт, шалгалт авах хугацаа гэх мэт тестэнд шаардлагатай өгөгдлүүдийг тухайн хичээлийг зааж буй багш оруулж өгөх бөгөөд оюутан та <https://sisi.num.edu.mn/test> хаягаар тестийн систем рүү өөрийн СиСи эрхээр нэвтрэн орно. Та системд нэвтэрснээр таны шалгалт өгөх хичээлийн харалдаа *Шалгалт өгөх* товч идэвхжсэн байх бөгөөд энэ товчин дээр дарснаар тестийн шалгалт эхлэх болно. Оюутан таны оноо шалгалтын хугацаа дуусахад шууд бодогдон гарах болно.

Энэ улиралд байгаа шалгалтууд				
Шалгалт	Хичээлийн нэр	Эхлэх	Дуусах	Оноо
14.00-2013 намар Явц	Өгөгдөл давжуулах үндэс	2013-11- 08T14:19:00	2013-11- 08T14:32:00	5
2014.04.10- 11tsag	Компьютерийн сүлжээ	2014-04- 10T11:50:00	2014-04- 10T12:23:00	0
2014.4.10- 14tsag	Компьютерийн сүлжээ	2014-04- 10T15:07:00	2014-04- 10T15:40:00	<input type="button" value="Шалгалт өгөх"/>

3. ХИЧЭЭЛ БҮРТГҮҮЛЭЛТ

МУИС-ын оюутан улирал бүр өөрийн үзэх хичээлд бүртгүүлэх ёстой. Хичээлд бүртгүүлэлт 2 үе шаттай явагддаг


✓ **Санал:** Оюутан хичээлийн улирлын 13, 14 дэх долоо хоногт багтаан, дараагийн улиралд заавал судлахаас гадна сонгож судлах хичээлд санал өгнө.

✓ **Баталгаажуулалт:** Ирэх улиралд орох хичээл, анги танхим, цаг, багшийн талаарх мэдээлэл бүхий хичээлийн ерөнхий хуваарийг салбар сургалтын алба бэлэн болгосны дараа журамд заасан хугацаанд оюутан хичээлийн хуваариудаас сонгож бүртгүүлэн сургалтын төлбөр төлж баталгаажуулна.

3.1 Хичээлд бүртгүүлэлт санал:

Хичээлд бүртгүүлэлтийн саналын үе нь оюутан дараагийн улиралд өөрийн сургалтын төлөвлөгөөн дэх үзээгүй хичээлүүдээс ямар хичээлийг үзэх хүсэлтэй байгааг тодруулах зорилготой. Суралцагчийн саналыг үндэслэн тэнхим сургалтын алба дараагийн улиралд ямар хичээлийг аль багш хичнээн заах мөн хичнээн оюутан суралцахыг тодорхойлж дараагийн улирлын хичээлийн хуваарийг боловсруулдаг.

Саналыг сургалтын нэгдсэн албанаас нээсэн тохиолдолд таны нүүр хуудсанд багшийн санал асуулгад оролцох товч идэвхжинэ. Тухайн улиралд судалсан бүх хичээлийн багшийн санал асуулгад оролцсоны дараа дараагийн улиралд үзэх хичээлдээ санал өгөх болно.



Тухайн улиралд судалж буй бүх хичээлийнхээ багшийн санал асуулгад оролцсоны дараа нүүр хуудасны Мэдээ хэсэг болон үндсэн цэсний Хичээлд бүртгүүлэх -> Санал хэсэгт дараагийн улиралд үзэх хичээлдээ санал өгөх эрх нээгдэнэ.



Санал өгөх хэсэгт таны сурч буй төлөвлөгөөний бүх хичээлүүд санал өгөх боломжтой, боломжгүй тайлбарын хамт гарч ирнэ. Тухайн хичээлийн урд ногоон таван хошуу байвал та тэр хичээл санал өгөх боломжтой.


Ногоон таван хошуун дээр дарахад дараах асуулт гарч ирэх бөгөөд санал өгөх бол ОК товчин дээр үгүй бол Cancel товчин дээр дарна.

Санал өгсөн хичээл дараах байдалтай харагдах бөгөөд саналыг цуцлахаар бол Цуцлах товчин дээр дарна.

★	Судалсан эсвэл судалж байгаа
★	Сонгох боломжтой
☆	Судлах боломжгүй
A. ЕРӨНХИЙ СУУРЬ ХИЧЭЭЛ	
A1. ЗААВАЛ СУДЛАХ ХИЧЭЭЛ	
★	SPRT101 36ц Биеийн тамир
★	HIST101 36ц Монголын түүх
★	FNDP100 06ц Гамшигаас хамгаалах менежментийн үндэс
★	PENG200 26ц Мэргэжлийн англи хэл
★	ENGL100 26ц Англи хэл I
★	ENGL100 26ц Англи хэл II
цуцлах	ENGL100 26ц Англи хэл 3
Сонгосон багш:	

3.2 Хичээлд бүртгүүлэлт баталгаажуулалт:

Бакалаврын Сургалтын Албанаас хичээлд бүртгүүлэлт (Баталгаажуулалт) нээсэн тохиолдолд оюутан та эрхээрээ нэвтрэн ороход дараах хэсэг гарч ирэх болно. Энд дарж орно уу гэсэн хэсэг дээр дарахад хичээл сонгох хэсэг гарч ирнэ.



Хичээл сонгох хэсэг рүү хандах хэсэг

Үндсэн мэдээлэлтэй танилцах

Оюутан таны сургалтын төлөвлөгөөнд байгаа хичээлүүд доорх тэмдэглэгээний хамт гарч ирэх бөгөөд тус бүр утга илэрхийлнэ.

- ✓ Баталгаажуулсан хичээл
- ★ Судлах боломжтой
- ★ Судлах боломжтой боловч хичээлийн хуваарь бэлэн биш
- ★ Судлах боломжтой боловч хичээлийн хуваарьт тавигдаагүй
- ★ Судалсан эсвэл судалж байгаа
- ★ Судлах боломжгүй
- ★ Судлах боломжгүй хичээл сонгосон
- ★ Хичээлд санал өгөөгүй, хичээл сонголтын үргэлжлэх хугацааны 1/2-с хойш сонгох боломжтой.

Тухайн хичээлүүдийн төлөв буюу тэмдэглэгээ. Эндээс цэнхэр таван хошуу буюу Судлах боломжтой боловч хичээлийн хуваарьт тавигдаагүй байвал Сургалтын Албандаа хандана уу!!!

Оюутан таньд тус болохуйц мэдээллүүд дараах байдлаар харагдах болно.

Үндсэн мэдээлэл

Нийт судалсан кредит: 54

Туслах мэдээлэл

Максимум кредит: 21
Нэг кредитийн төлбөр: 39900₮
Суралцаж буй түвшин: 2

Баталгаажгаагүй кредитийн мэдээлэл

Нийт сонгосон кредит: 0
Кредитийн төлбөр: 0.00₮
Суурь хураамж: 100000₮
Нийт төлбөр: 100000.00₮

Нийт судалсан кредит

Тухайн улиралд суралцах кредитийн дээд хязгаар кр-ийн төлбөр Суралцаж байгаа түвшин

Сонгосон кредитийн мэдээлэл болон төлбөл зохих төлбөрийн мэдээлэл

Баталгаажсан кредитийн мэдээлэл

Нийт сонгосон кредит: 0
Кредитийн төлбөр: 0.00₮
Суурь хураамж: 0₮
Нийт төлбөр: 0.00₮
Таны дансны үлдэгдэл: 0.00₮

Баталгаажсан кредит болон төлбөр

СиСи дансны үлдэгдэл

Таны суралцаж буй түвшин судалсан кредитээс хамаарна.

Судалсан кредит	Түвшин
0-30	1
31-60	2
61-90	3
90-с их	4

Оюутан хэдэн кр цуглуулснаас хамаарч суралцаж буй түвшин тодорхойлогдоно.

Хуваарь сонгох

Үндсэн мэдээлэлтэй сайтар танилцсаны дараа өөрийн судлах хичээлийн хуваарийг зохионо. Сонгох боломжтой хичээлүүд дээр дурдсаны адил урдаа ногоон таван хошуутай харагдах бөгөөд хичээл бүрийн урд байгаа тэмдэглэгээн дээр заагчаа / хулгана / аваачихад тэмдэглэгээний тайлбар гарч ирнэ.

ерөнхий суурь хичээл

Заавал судлах хичээл

Судлах боломжтой 00 3 бц Судалгааны технологи, мэдээллийн систем

2 ★ HIST100 3 бц Монголын түүх

Заагчаа аваачихад тайлбар гарч

Сонгох боломжтой хичээл буюу ногоон таван хошуу дээр дарахад тухайн хичээлийн сонгох боломжтой хуваариуд гарч ирнэ.

Хичээлийн хуваарь

Монголын түүх (HIST100)

Лекц

Дашдулам Д - 18/90 (12:20-13:50 - Пхэгва) Хичээлийн төв байр-А

Баянжаргал С - 37/110 (17:20-18:50 - Мэгмар) Хичээлийн байр 9-310

Энхцэцэг Д - 41/140 (12:20-13:50 - Даваа) Хичээлийн байр 5-305

Бүжигтхам Б - 11/150 (17:20-18:50 - Даваа) Хичээлийн төв байр-330

Билэгт.Л - 11/144 (17:20-18:50 - Мэгмар) Хичээлийн төв байр-310

Энжаргал Д - 49/160 (17:20-18:50 - Баасан) Хичээлийн байр 5-605

Базардорж Д - 29/180 (17:20-18:50 - Баасан) Хичээлийн байр 3А-331

Баасанжав Э - 34/160 (09:00-10:30 - Пүрэв) Хичээлийн байр 2-А танхим

Бүлэг-3779

Олгонжаргал С - Пхэгва - 120/120 (15:40-17:10) Хичээлийн байр 4-221

Олгонжаргал С - Пхэгва - 120/120 (17:20-18:50) Хичээлийн байр 4-221

Сүхбаатар Д - 56/240 (14:00-15:30 - Баасан) Хичээлийн байр 7-114

Чулунбаатар Л - 41/160 (09:00-10:30 - Баасан) Хичээлийн байр 2-А танхим

Ганбат С - 18/160 (15:40-17:10 - Даваа) Хичээлийн байр 2-А танхим

Семинар

Гонгоржав У - 10/30 (14:00-15:30 - Пхэгва) Хичээлийн байр 8-206

Гонгоржав У - 10/30 (12:20-13:50 - Пүрэв) Хичээлийн байр 8-206

Гонгоржав У - 2/30 (14:00-15:30 - Пүрэв) Хичээлийн байр 8-206

Гонгоржав У - 6/40 (15:40-17:10 - Пхэгва) Хичээлийн байр 2-178

Тухайн лекцийг сонгоход семинар эсвэл лаборатори автоматаар гарч ирнэ.

Лекцийг сонгоход лаборатори эсвэл семинар автоматаар гарч ирэх / хэрвээ лекц байхгүй бол лаборатори эсвэл семинарыг сонгоно / ба хуваариудаа бүрэн сонгосны дараа Сонгох товчийг даран хуваари сонгоно. Мөн семинарыг дарахад лаборатори гарч ирэх ч тохиолдол бий.

Амжилттай сонгосон хичээл хуваарийн хамт дараах байдлаар харагдах ба Цуцлах товчийг даран хуваарийг цуцалж болно.

ерөнхий суурь хичээл				
Заавал судлах хичээл				
1	★	СОМР100	3 6ц	Мэдээллийн технологи, мэдээллийн систем
2	★	ННСТ100	3 6ц	Монголын түүх

Сонгосон хичээлийг цуцлах

Цуцлах

Семинар Гонгоржав.У (Лхагва 14:00-15:30)
Лекц Гонгоржав.У (Мягмар 17:20-18:50)

Хичээл баталгаажуулах

МУИС-ийн сургалтын систем нь банкны онлайн төлбөр тооцооны системтэй холбогдсон бөгөөд тус сургуулийн суралцагчид сургалтын төлбөрөө онлайн гүйлгээний эрхтэй, дотоодын картаар төлөх болно.

Хичээл сонголтыг баталгаажуулсанаар та тухайн хичээлд албан ёсоор бүртгэгдэх ба баталгаажуулахын тулд тухайн улиралд судлах кредитийн төлбөр болон суурь хураамж заавал төлөх болно.



Хичээл баталгаажуулсаны дараа хичээлийг цуцлах бол нэмэлт төлбөр төлөх болохыг анхааран **сонголт**оо хариуцлагатай хийгээрэй.

Баталгаажуулах

Баталгаажуулалт нь банкны системтэй холбогдсон бөгөөд багцын төлбөрийг онлайн хэлбэрээр төлөх болно.

Сонгосон кредит болон төлбөрийн мэдээлэл	
Нийт кредит:	2.00
Нэг кредитийн төлбөр:	47900.00
Нийт кредитийн төлбөр:	95800.00
Суурь хураамж:	100000
Хоцорсон бүртгэлийн төлбөр:	0
Төлбөл зохих:	195800.00
Дансны үлдэгдэл:	0.00

Төлбөр төлснөөр таны сонгосон хичээлүүд баталгаажих болно.

Хаан банкаар

Голомт банкаар

МУИС-ийн оюутан хичээл сонголт хийсний дараа сонгосон кредит цаг болон суурь хураамжийг нэхэмжилсэн хуудас банкны системд очих бөгөөд төлбөрөө төлөхдөө тухайн банкны гүйлгээний эрхтэй карт хэрэглэнэ.

Таны SISI-гийн дансанд байрлах илүү болон дутуу төлөлт одоогийн хичээл сонголтын төлбөрт тооцогдоно. (Жишээ нь: Таны дансанд 200'000 төгрөгний илүү төлөлт байгаа бөгөөд та 500'000 төгрөгний хичээл сонгож байгаа тохиолдолд та 300'000 төгрөг төлнө. Эсвэл та 200'000 төгрөгний дутуу

төлөлттэй бол та 700'000 төгрөг төлнө.) SISi дэх дансны үлдэгдлийг баталгаажсан кредитийн мэдээлэл хэсгээс харна уу.

Баталгаажсан кредитийн мэдээлэл

Нийт сонгосон кредит: 0
 Кредитийн төлбөр: 0.00₮
 Суурь хураамж: 0₮
 Нийт төлбөр: 0.00₮
 Таны дансны үлдэгдэл: -200'000.00₮

Баталгаажуулалтын төлбөрийн хэсэг нь банкны системтэй хамтарч ажилдаг учир гүйлгээ хийх картны мэдээллийг тухайн банк хариуцна.

4. ЦАХИМ ЖУРНАЛ

Цахим журнал нь багшийн бүртгэсэн ирцийн мэдээлэл болон багшийн өгсөн даалгаврыг харах, буцаан даалгавраа илгээх, багшийн өгсөн үнэлгээг харах гэх мэт боломжуудтай. Та оюутны цахим журналыг хэрэглэхдээ системийн нүүр хуудсанд байрлах тухайн улиралд судалж буй хичээл дээр даран гарч ирэх хэсгээс *Журнал* хэсгийг сонгоно.

Судалж буй хичээлүүд

CSSW223 - Объект хандлагат програмчлал (3 кр)

HIST100 - Монголын түүх (3 кр)

ITCM351 - Телехолбооны үндэс (3 кр)

ELEC211 - Электрон элемент ба хэлхээ (4 кр)

ELEC112 - Цахилгаан хэлхээ (3 кр)

COMP223 - Микропроцессор (3 кр)

Хичээлийн мэдээлэл
Хуваарь
Журнал
Санал асуулга эхлээгүй

4.1 Ирц бүртгэл

Цахим журналын ирц бүртгэлийн мэдээллийг харахын тулд *Журнал* хэсгийн гарч ирэх талбараас *Ирц бүртгэл* хэсгийг сонгох ба энд тухайн хичээл дээр оюутан таны лекц, семинар, лабораторийн ирцийн бүртгэл оролт тус бүрээр тайлбарын хамт харагдана.

	Даалгавар						Ирц бүртгэл						
	2014/2/12	2014/2/19	2014/2/26	2014/2/5	2014/3/12	2014/3/19	2014/3/26	2014/3/5	2014/4/16	2014/4/2	2014/4/23	2014/4/30	
Лекц	✔	✔	✔	✔	✔	●	✔	✔	✔	●	●	✔	<ul style="list-style-type: none"> ✔ Ирсэн ○ Чөлөөтэй ● Өвчтэй ● Тасалсан
	2014/2/13	2014/2/20	2014/2/27	2014/2/6	2014/3/13	2014/3/20	2014/3/27	2014/3/6	2014/4/10	2014/4/17	2014/4/24	2014/4/3	
Лаборатори	✔	✔	✔	✔	✔	✔	✔	✔	✔	✔			

4.2 Даалгавар

Цахим журналын багшийн өгсөн даалгаврын мэдээллийг харахын тулд *Журнал* хэсгийн гарч ирэх талбараас *Даалгавар* хэсгийг сонгох ба энд багшийн өгсөн бүх даалгавруудын мэдээлэл, таны авсан онооны хамт хүснэгт хэлбэрээр харагдана. Мөн тухайн даалгаврын харгалзах *Дэлгэрэнгүй* товчин дээр дарснаар даалгаврын дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.

Даалгавар							Ирц бүртгэл
№	Даалгаврын нэр	Төрөл	Оноо	Эхлэх өдөр	Дуусах хугацаа	Авсан оноо	Дэлгэрэнгүй
1	Lab1	Лаборатори	3	2014/2/20	2014/2/27	3	Дэлгэрэнгүй
2	Lab2	Лаборатори	3	2014/2/24	2014/3/3	3	Дэлгэрэнгүй
3	Lab3	Лаборатори	3	2014/2/27	2014/3/6	3	Дэлгэрэнгүй
4	LAB5	Лаборатори	3	2014/3/20	2014/3/27	3	Дэлгэрэнгүй

Дэлгэрэнгүй товчин дээр дарснаар тухайн даалгаврын дэлгэрэнгүй мэдээлэл гарч ирэхээс гадна тухайн даалгавар нь оюутнаас файл хүлээж авах даалгавар бол оюутан та энэ хэсэгт даалгавраа илгээх болно.

Даалгаврын мэдээлэл

Даалгаврын нэр: Лекцүүд

Гүйцэтгэх хугацаа: Эхлэх өдөр :2014.6.17- Дуусах өдөр:2014.6.25

Даалгаврын оноо: 0

Лекцийн материал
Татах линк: <http://share.gogo.mn/n0JEbsqX8P85731400463677>

Та даалгавраа илгээхийг хүсвэл файлуудаа "Browse..." товчийг дарж сонгоод " илгээх" товчийг дарж илгээнэ үү. Нэгэнт илгээсэн үед дахин илгээх боломжгүй тул файлаа зөв сонгож илгээнэ үү.

Choose File No file chosen
Choose File No file chosen
Choose File No file chosen

Даалгавар илгээх

Хаах

5. ТӨГСӨХ ХҮСЭЛТ ГАРГАХ

Оюутан та бакалаврын сургалтын журмын дагуу тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд системээр өөрийн төгсөх хүсэлтийг гаргана. Төгсөх хүсэлт гаргахын тулд үндсэн цэсний *Төгсөх хүсэлт* цэсийг сонгоно. Энэ хэсэгт таны төгсөх хүсэлт гаргахад шаардлагатай мэдээллүүд байх бөгөөд доод хэсэгт байрлах *Төгсөх хүсэлт гаргах* товчин дээр дарахад төгсөх хүсэлт илгээгдэх болно.



ХИЧЭЭЛД БҮРТГҮҮЛЭХ, БАТАЛГААЖУУЛАХ

Хичээлд бүртгүүлэх үйл ажиллагаа нь хичээлд санал өгөх, баталгаажуулалт гэсэн хоёр үе шаттай, цахим хэлбэрээр явагдана.

Бакалаврын өдрийн хөтөлбөрийн хувьд оюутан улиралд дунжаар 15 багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судалбал зохих багц цагийн доод хэмжээ 12, дээд хэмжээ 21 байна.

Магистрын хөтөлбөрийн хувьд улиралд дунджаар 10 багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судалбал зохих багц цагийн дээд хэмжээ 12 (*ХЗС бол 13*) байна. Докторын хөтөлбөрийн хувьд улиралд дунджаар 10 (*эчнээ бол 6*) багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судалбал зохих багц цагийн дээд хэмжээ 15 (*ХЗС бол 13*) байна.

Суралцагч судалж буй хичээлийн агуулга, чанар, багшийн заах арга, ёс зүй, харилцаа, суралцах орчны талаарх судалгааг цахим хэлбэрээр өгснөөр дараа улирлын хичээлийн санал өгөх эрх нээгдэж тухайн улирлын 13, 14 дэх долоо хоногт багтаан дараагийн улиралд судлах хичээлд санал өгнө. Санал өгснөөр хичээл баталгаажуулалтын хугацааны 50 хувьд тухайн хичээлийг баталгаажуулах давуу эрх эдэлнэ.

Мэргэжлийн тэнхим, хөтөлбөрийн дэд хороо хичээлийн саналыг үндэслэж 15, 16 дахь долоо хоногт багтаан хичээл орох багшийг эцэслэн тодорхойлж, дараагийн улиралд орох хичээл, заах багшийн нэр, анги танхим, цаг бүхий хичээлийн хуваарийг улирлын шалгалтын хугацаанд бэлэн болгоно.

Суралцагч хичээлийн хуваарийг үндэслэн тухайн улирал эхлэхээс өмнөх долоо хоногт (*0 долоо хоног*) хичээлд бүртгүүлэх ба 24 цагийн дотор бүртгүүлсэн хичээлийн багц цагийн төлбөр, тухайн улирлын суурь үйлчилгээний төлбөрийг цахим хэлбэрээр төлж, баталгаажуулна. Суралцагч баталгаажуулсан хичээлийг хичээлд бүртгүүлэн, баталгаажуулах хугацаанд өөрөө цуцалж болно.

Магистр, докторын эрдэм шинжилгээний ажил, магистрын судалгааны ажил, докторын диссертацийг төгсөх улиралдаа сургалтын мэдээллийн системээр сонгон баталгаажуулна.

Хүндэтгэн үзэх шалтгаанаар заасан хугацаанд хичээлдээ бүртгүүлж амжаагүй суралцагч тухайн улирлын эхний 7 хоногт багтан бүртгүүлэх боломжтой хичээлд бүртгэлийн хураамж төлж бүртгүүлнэ. Бүртгэлийн хураамж нь тухайн хичээлийн 1 багц цагийн төлбөртэй дүйцэхүйц байна.

Улирлын хичээл эхэлснээс хойш, сургалтын төлөвлөгөөн дэх тухайн хичээлийн цагийн 30 хувь өнгөрөөгүй байхад баталгаажуулсан хичээлээ цуцлах тохиолдолд хичээлийн багц цагийн төлбөрийн 70 хувийг дараагийн улиралд бүртгүүлэх хичээлийн багц цагийн төлбөрт шилжүүлнэ. Хичээлийн цагийн 30-аас дээш хувь өнгөрсөн бол багц цагийн төлбөрийг буцааж олгохгүй. Аль ч тохиолдолд тухайн улирлын суурь үйлчилгээний төлбөрийг буцааж олгохгүй.

СУРАЛЦАГЧИЙН МЭДЛЭГ, ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

Хичээлээр эзэмшсэн суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэхдээ тэдний бие даан суралцах үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, хөгжүүлэх, оюутны сурах, багшийн сургах хариуцлагыг өндөржүүлэх зарчмыг удирдлага болгох бөгөөд үнэлгээ шинжлэх ухааны үндэстэй, бодитой, шударга, ил тод байна. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлж дүгнэх гол хэлбэр нь шалгалт байна.

Суралцагчийн сурлагын чанарыг улирал бүрийн, мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнгээр тодорхойлно. Голч оноо, голч дүнг бодохдоо багц цаг бүхий хичээл бүрээр оюутны авсан оноо/дүнг харгалзах багц цагаар нь үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг багц цагийн нийлбэрт хувааж (арифметикийн жинлэсэн дундаж), таслалаас хойш нэг орны нарийвчлалтай бодож гаргана.

$$ГО = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot O_i}{\sum_{i=1}^n K_i} \quad ГД = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot Д_i}{\sum_{i=1}^n K_i}$$

n - хичээлийн тоо

K_i - тухайн (i) дугаар хичээлийн багц цаг

$O_i (Д_i)$ - тухайн (i) дугаар хичээлийн оноо (дүн)

$ГО (ГД)$ - голч оноо (голч дүн)

Суралцагч улирал бүр тухайн улирлын мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнтэйгээ танилцан, сурлагынхаа байдалд үнэлэлт дүгнэлт хийж цаашид суралцах үйл ажиллагаагаа төлөвлөнө.

Суралцагчийн голч оноо, голч дүнг улирал, хичээлийн жил, суралцсан хугацаа, мэргэжлийн хөтөлбөр, бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд суралцагчийг байр эзлүүлэхэд ашиглах буюу оюутныг үндсэн мэргэжлийн хөтөлбөр сонгуулах, хавсарга болон хос мэргэжил эзэмшүүлэх, бакалавр, магистрын зэргэцсэн хөтөлбөрт суралцуулах, суралцагчийг шагнах, тэтгэлэг олгохоор тодорхойлох, магистр, докторын зэргэцсэн хөтөлбөрт суралцуулах, төгсгөх, оюутан солилцооны хөтөлбөрт хамруулах, магистр, докторын хөтөлбөрт үргэлжлүүлэн сургах зэрэгт гол үзүүлэлт болгоно.

Семинар, лабораторийн хичээл, судалгааны ажил бусад бие даалтын ажлаар олсон мэдлэг, чадварыг үнэлэхэд төсөл, тайлан хамгаалалт, явцын шалгалт, тест, ангийн ажил болон тэдгээртэй дүйцэх бусад хэлбэрийг ашиглах ба мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлээр хийх дадлагад багц цаг харгалзуулсан бол тэдгээрийн тайлангийн хамгаалалтыг шалгалтын нэгэн адил үзэж оноогоор үнэлнэ.

Ерөнхий суурь хичээлийн үнэлгээ

Ерөнхий суурь хичээлийн шалгалтыг тест болон бусад хэлбэрээр авах ба явцын болон улирлын тест (сорилго) хэлбэрийн шалгалтыг сургалтын алба зохион байгуулж суралцагчидын дүнгийн мэдээллийг хичээл зааж буй багшид ажлын 2 хоногийн дотор өгнө.

Ерөнхий суурийн англи хэлний хичээлийн агуулгын шаардлагыг хангасан мэдлэгтэй суралцагч нь тухайн чиглэлээр гадаад хэлний төвд шалгалт өгч эсвэл TOEFL, IELTS-ийн харгалзах түвшний онооноос дээш оноотой, МУИС-ийн харъяа байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай “Байгаль-Эх” лицей ахлах сургууль болон МУИС-тай багц цаг тооцох гэрээ байгуулсан ахлах сургуулийг төгссөн сурагч ерөнхий суурь хичээлийн байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухааны багцаас гүнзгийрүүлэн судалсан 85-аас дээш үнэлгээтэй хичээлийг дүйцүүлэн тооцуулж болно.

Суралцагчийн тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээ

Тухайн хичээлээр суралцагчийн улирлын туршид эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээг гаргахдаа оюутны хичээлийн явцын идэвх оролцоо, бие даасан ажиллагааны завсрын хяналтын үнэлгээ, улирлын шалгалтын үнэлгээ тус бүрийг зохих хэмжээгээр тооцон 100 оноогоор үнэлнэ.

$$O = O_1 + O_2 + O_3$$

Үүнд:

- O₁** - Идэвх, оролцооны үнэлгээ. Хичээлд оролцсон бүтээлч ирц, семинар, дадлагын хичээлд бэлтгэсэн оноо байна.байдал зэрэгт багшийн өгсөн үнэлгээ бөгөөд 20-40 оноо байна.
- O₂** - Суралцагчийн явцын үнэлгээ. Улирлын явцад хийсэн илтгэл, реферат, тайлан, хяналтын ажил, коллеквиум, сэдвийн үнэлгээний дундаж болон явцын шалгалтын нийлбэр бөгөөд 20-40 оноо байна.

О₃ - Улирлын шалгалтын үнэлгээ бөгөөд 20-60

Тайлбар:

- Суралцагчийн ирц, идэвх оролцоог бүртгэн үнэлэх боломж хязгаарлагдмал хичээлийн хувьд тэнхим хэлэлцэж, O₁ оноог хамгийн бага боломжит хэмжээнд тогтоож болно.
- Хичээл бүрийн хөтөлбөрт тухайн хичээлээр суралцагчийн олж авсан мэдлэг, чадварыг үнэлэх онооны хуваарилалтыг хэдэн ч хэсгээр хийсэн байж болох ба багш түүнийг баримтлана.
- O₁, O₂, O₃ үнэлгээ нь бүхэл тоон нарийвчлалтай байна.

Хичээлд 60 ба түүнээс дээш оноо авсан суралцагчийг уг хичээлийн агуулгыг судалж, багц цагийг биелүүлсэн гэж үзнэ. Харин 60-аас бага оноо авсан суралцагчийг “хангалтгүй” суралцсан буюу тухайн хичээлийн багц цагийг биелүүлээгүй гэж үзнэ. Мөн багц цаг тооцохгүй хичээлийн шалгалтыг авахдаа шалгалтын адил 100 оноогоор үнэлнэ. Суралцагчийн авсан оноо нь 60 ба түүнээс дээш бол “тооцов”, 60-аас доош бол “үл тооцов” гэж дүгнэх бөгөөд үнэлгээг харгалзан “S”, “U” гэж бичнэ.

Хувьчилсан оноо, үсгээр илтгэсэн дүн ба тоогоор илтгэсэн дүнгийн хоорондын холбоо дараах хэлбэртэй байна. Үүнд:

Хувьчилсан оноо	Үсгээр илтгэсэн дүн	Тоогоор илтгэсэн дүн
95-100	A	4.0
90-94	A-	3.6
85-89	B	3.1
80-84	B-	2.7
75-79	C	2.3
70-74	C-	1.9
65-69	D	1.4
60-64	D-	1.0
0-59	F	0

Суралцагчийг үнэлэхдээ тоо болон үсгээр илтгэсэн дүнг хэрэглэхээс гадна I, E, NC, CR, R, W, NA, NR, S, U гэсэн нэмэлт тэмдэглэгээг хэрэглэнэ. Эдгээр тэмдэглэгээ нь суралцагчийн голч дүн буурах шалтгааныг тогтоох, суралцагч голч дүнгээ хянах, дүнгээ ахиулах боломж олгох, бусад сургуулийн багц цагийг шилжүүлэн тооцох зэрэгт хэрэглэгдэнэ.

I	(Incomplete) Хүндэтгэн үзэх шалтгаанаар явцын үнэлгээ (реферат, даалгавар, дадлагын ажил дутуу, явцын шалгалтанд орж чадаагүй гэх мэт) дутуу боловч шалгалтын хугацаанд нөхөн гүйцэтгэж, шалгуулах нөхцөлтэйгээр хэрэглэнэ.
E	(Examine incomplete by student) Хүндэтгэн үзэх шалтгаанаар улирлын шалгалтанд ороогүй бол багш (эсвэл сургалтын албаны эрхлэгч) энэ тэмдэглэгээг бичнэ.
NC	(No Credit) Багц цаг тооцохгүй бөгөөд уг хичээлийг суралцагч судалсан гэсэн тэмдэглэгээ. Кредит тооцуулахгүйгээр хичээл судлах зөвшөөрөл авч амжилттай судалсан тохиолдолд тавигдах тэмдэглэгээ юм.
CR	(Credit granted) Өөр сургуулийн багц цагийг шилжүүлэн тооцох үед энэ тэмдэглэгээг хийх ба дипломын хавсралтан дээр энэ хэвээрээ бичигдэнэ.
R	(Repeat) Тухайн хичээлийг амжилттай судалсан ч тодорхой шаардлагаар дахин судлах хүсэлт гаргасан бол суралцагчийн өмнөх үнэлгээний үсгээр илтгэсэн дүнг R болгож, дахин судлах боломжоор хангана.
	(Withdrew)

W	<i>Хэрэв суралцагч хичээлийг цаашид судлах боломжгүй эсвэл хангалтгүй судалсан бол улирлын шалгалтаас 7 хоногийн өмнө өөрийн саналаар уг тэмдэглэгээг багшид хүсэлт гаргаж хийлгэнэ. Суралцагч чөлөө авсан, хасагдсан, гарсан тохиолдолд дүгнэгдээгүй хичээлийн дүнг системээс тавина. Дараа нь тус хичээлийг шинээр үзэх хичээлийн адил бүртгүүлж судална.</i>
NA	(grade Not yet Available) <i>Одоогоор дүгнэгдээгүй буюу судалж байгаа хичээлийн тэмдэглэгээ.</i>
NR	(No grade Reported) <i>Багш эцсийн үнэлгээгээ үнэлгээ тавих хугацааны дотор тавьж, системд оруулаагүй тохиолдолд мэдээллийн системээс автоматаар тавьсан тэмдэглэгээ.</i>
S	(Satisfactory) <i>"Тооцов" тэмдэглэгээ.</i>
U	(Unsatisfactory) <i>"Үл тооцов" тэмдэглэгээ.</i>

Явцын болон улирлын шалгалтыг 1 удаа тус тус авч шалгагч багш дүнгээ шалгалт авсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор мэдээллийн системд оруулах үүрэгтэй.

Улирлын явцад хичээлд байнга идэвхтэй оролцсон, тухайн хичээлийн явцын шалгалтын бүх хэлбэрүүдэд амжилттай үнэлэгдсэн, үлгэр жишээч оюутанд уг хичээлийн улирлын шалгалтын үнэлгээг шууд тавихыг үгүйсгэхгүй бөгөөд уг асуудлыг багш суралцагчийн хамт олонд мэдэгдэн, ил тод шийднэ. Шууд дүгнэгдэх суралцагчийн тоо нийт шалгагдах суралцагчийн 10%-аас хэтрэхгүй байна.

Хүндэтгэх шалтгаангүйгээр улирлын шалгалтанд ирээгүй суралцагчид "F" буюу "хангалтгүй" үнэлгээ тавина. Харин хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол нотлох бичиг баримтыг үндэслэн "E", "I" тэмдэглэгээг хийх ба суралцагч дараагийн улирлын эхний 1 сард багтаан шалгуулахгүй бол сургалтын албанаас F дүн тавина.

Нэмэлт тэмдэглэгээ тавигдсан хичээлийн багц цагийг улирлын болон нийт голч оноо, голч дүнг бодоход хэрэглэхгүй.

Магистрын хөтөлбөрийн хувьд мэргэжлийн гадаад хэлний хичээлийн агуулгын шаардлагыг хангасан мэдлэгтэй суралцагч нь тухайн чиглэлээр шалгалт өгч дүйцүүлэн тооцуулж болно.

Магистр, докторын эрдэм шинжилгээний ажлын багц цагийг тооцох комиссыг бүрэлдэхүүн сургуулийн тэнхмийн эрхлэгч, тэнхимгүй бүтцийн хувьд хөтөлбөрийн удирдагчийн саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулж эрдэм шинжилгээний ажил, магистрын ажил, докторын диссертацийн дүнг сургалтын мэдээллийн системд тэнхмийн эрхлэгчид оноож үнэлгээг оруулна.

Дахин судлах хичээлийн үнэлгээ

Заавал судлах хичээлийг судалж, амжилтгүй дүн авсан, мөн "R", "W", "U", "NR" үнэлгээний тэмдэглэгээтэй суралцагч тухайн хичээлийн багц цагийг биелүүлэхийн тулд дахин судална.

Суралцагч хичээлийг судалж, амжилттай үнэлгээ авсан ч тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвар, үнэлгээгээ ахиулах зорилгоор дахин судалж болно. Суралцах хугацаанд дахин судлах хичээлийн тоо 3 хүртэл байна.

Суралцагч судалж, дүгнэгдсэн хичээлээ дахин судлах тохиолдолд, сургалтын албанд хүсэлтээ гаргаж, сургалтын мэдээллийн системд өмнөх үнэлгээг "R" болгож тэмдэглүүлнэ. "R" үнэлгээ тавиулсан тохиолдолд өмнөх дүнг хүчингүй болгох бөгөөд буцаах боломжгүй.

СУРАЛЦАГЧ ЧӨЛӨӨ АВАХ

Суралцагч хүндэтгэн үзэх шалтгаанаар 21 хоногоос богино хугацаагаар чөлөө авах бол багшийн зөвшөөрлийг үндэслэн сургалтын алба шийдвэрлэх ба 3 долоо хоногоос дээш хугацаагаар хичээлд сууж чадахгүйд хүрвэл, сургалтын албанд улирлын чөлөө авах тухай хүсэлтээ бичгээр гаргаж сургалтын мэдээллийн системд суралцагчийн төлвийг сургалтын алба өөрчилж сонгосон хичээлийг цуцална.

Нэг удаагийн чөлөөний хугацаа 2 хүртэл улирал байж болно. Суралцагчийн суралцах хугацаанд олгох чөлөөний нийт хугацаа 2 жилээс хэтрэхгүй байна.

Улирлын чөлөө авах тохиолдолд тухайн улирлын суурь үйлчилгээний төлбөрийг буцааж олгохгүй ба чөлөө авсан, идэвхгүй төлөвт байгаа суралцагчид улирал бүр суурь үйлчилгээний төлбөрийг төлнө.

СУРАЛЦАГЧ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН СУРАЛЦАХ

Чөлөөний хугацаа дууссан суралцагч улирлын хичээл эхлэхээс 7-гоос доошгүй хоногийн өмнө үргэлжлүүлэн суралцах өргөдлөө сургалтын албанд өгч шаардлагатай төлбөрийг төлсний үндсэн дээр бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар үргэлжлүүлэн суралцах эрх нээгдэж сургалтын мэдээллийн системд сургалтын алба суралцагчийн төлвийг өөрчлөнө.

Улирлын чөлөөг дуусгаад ирсэн болон бусад шалтгаанаар сургалтын хугацаа хойшлон суралцаж байгаа суралцагч сургалтын төлөвлөгөөний өөрчлөлтөөс болж хичээл, хөтөлбөрийн түвшин, шалгалтын зөрүү гарвал үргэлжлүүлэн суралцах болсон шалтгаан, өмнө нь авч байсан дүнг харгалзахгүйгээр нөхөн үзэх хичээл, өгөх шалгалтыг сургалтын алба, тэнхмийн эрхлэгч/хөтөлбөрийн удирдагч нар хамтран тогтооно.

Хоёр улирал дараалан идэвхгүй төлөвт байгаа суралцагч сургалтын албанд үргэлжлүүлэн идэвхтэй төлөвт суралцах хүсэлт гаргах ба идэвхгүй суралцсан хугацааны суурь үйлчилгээний төлбөрийг нөхөн төлнө.

СУРГУУЛИАС ЧӨЛӨӨЛӨГДӨХ

Суралцагч сургуулиас чөлөөлөгдөх тухай хүсэлтийг сургалтын албанд гаргасан тохиолдолд сургуулиас бүрмөсөн чөлөөлөх МУИС-ийн захирлын тушаал гарна.

Суралцагчийг дараах шалтгаанаар бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн шийдвэрээр МУИС-ийн захирлын тушаалаар сургуулиас хасна. Үүнд:

- Чөлөөний хугацаа дуусаад хичээлд бүртгүүлээгүй, эсвэл чөлөөг сунгах хүсэлт гаргаагүй,
- 4 улирал сургалт, судалгааны ажилд оролцоогүй,
- Суралцах үлдсэн хугацаанд нийт багц цагийг амжилттай цуглуулах боломжгүй болсон,
- Эзэмшсэн мэдлэг, чадвараа үнэлүүлэхдээ хуурч мэхлэх, дүнгийн тодорхойлолтыг хуурамчаар үйлдэх зэрэг зөрчил гаргасан,
- Гэмт хэрэг, ёс суртахууны ноцтой зөрчил гаргасан нь хууль, хяналтын байгууллагаар тогтоогдсон.

Суралцагч сургуулиас хасагдах тохиолдолд өөрт нь албан ёсоор мэдэгдэх ба ямарч төлбөрийг буцааж олгохгүй. Сургуулиас хасагдах нөхцөл бүрдсэн бөгөөд холбоо барих боломжгүй тохиолдолд сургуулиас хасна.

ТӨГСӨГЧДӨД ТАВИХ ШААРДЛАГА, ХҮСЭЛТ ГАРГАХ

Бакалаврын сургалтын төлөвлөгөөн дэх 120-оос доошгүй багц цаг цуглуулсан, сургууль/салбар, тэнхмээс холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн оюутанд дээд боловсролын бакалаврын зэрэг олгож төгсгөнө. Үүнд:

Бакалаврын хөтөлбөрийн төгсөгч нь англи хэлний ахисан дунд (upper intermediate) түвшний мэдлэг эзэмшсэн байх бөгөөд TOEFL, IELTS-ийн харгалзах түвшний онооноос дээш оноотой байна.

Бакалаврын сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийг бүрэн, мөн мэргэжлийн зарим хичээлүүдийг судалж 90-ээс (ХЗС 120) доошгүй багц цаг цуглуулан, хүндэтгэх шалтгааны улмаас төгсөх хүсэлт гаргасан оюутанд дээд боловсролын дипломын зэрэг олгож болно. Дипломын зэргээр төгсөгч нь төгссөнөөсөө хойш 3 жилийн дотор тухайн мэргэжлээр элсэлтийн шалгалтгүйгээр үргэлжлүүлэн суралцаж, багц цагаа амжилттай судалж гүйцээн журмын дагуу бакалаврын зэрэг авч болно.

Төгсөгч хавсарга эсвэл хос мэргэжлээр суралцах тохиолдолд сургууль/салбар, мэргэжлийн тэнхмээс холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн байна. Хос мэргэжлээр амжилттай суралцсан оюутанд давхар суралцсан мэргэжлийн хоёр дахь бакалаврын диплом олгоно.

Магистрын ажлын хамгаалалтын өмнөх хэлэлцүүлгийг тэнхмийн эрдэм шинжилгээний өргөтгөсөн семинарт хийнэ. Өргөтгөсөн семинараас дүгнэлт гаргаж, хуралдааны протоколын хамт бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд хүргүүлнэ. Семинарын товыг нийтэд зарлаж, нээлттэй хийж магистрын ажлыг магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаална.

Магистрын сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийг бүрэн судалж, сургууль/салбар, тэнхмээс холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн, мэргэжлийн магистрын хувьд 32, судалгааны магистрын хувьд 30-аас доошгүй багц цуглуулсан суралцагчийг дээд боловсролын магистрын зэргээр төгсгөнө.

Докторант сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, докторын зэрэг горилсон диссертацийн ажлаа тэнхим, бүрэлдэхүүн сургууль/салбар, мэргэжлийн эрдэмтэдийн өргөтгөсөн семинарт урьдчилан хэлэлцүүлсэн тухай дүгнэлт гарган докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд уламжилна. Семинарын товыг нийтэд зарлаж, нээлттэй хийнэ. Семинараас диссертацид мэргэжлийн дүгнэлт хийж, хуралдааны протокол гаргах ба энэ нь докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд МУИС-иас гаргаж өгөх дүгнэлтийн нэг үндэслэл болно.

Докторын диссертацийг монгол хэлээр бичнэ. Диссертацийн тухай товч танилцуулгыг англи хэлээр 3 хуудаст багтаан бичиж, диссертацийн эцэст хавсаргана. Горилогчийн хүсэлт, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн дийлэнх олонхийн зөвшөөрснөөр диссертацийн ажлыг англи хэлээр бичүүлж, хамгаалалтыг англи хэлээр явуулж болно. Энэ тохиолдолд диссертацийн тухай товч танилцуулгыг монгол хэлээр бичнэ.

Бакалаврын судалгааны ажил, магистрын судалгааны ажил, докторын диссертацийг захирлын тушаалаар батлагдсан загварын дагуу бичиж, хэвлүүлнэ.

Докторын сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийг бүрэн судалж, сургууль/салбар, тэнхмээс холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн, 60-аас доошгүй багц цуглуулсан, докторын диссертация амжилттай хамгаалсан суралцагчийг дээд боловсролын докторын зэргээр төгсгөнө.

Бакалаврын зэрэг горилогчийн суралцсан хугацааны голч дүн 1.8 ба түүнээс их, магистр, докторын зэрэг горилогчийн суралцсан хугацааны голч дүн 2.3 ба түүнээс их байна.

Төгсөгч нь сургалтын төлбөрийн болон бусад тооцоогүй байна.

Төгсөх хүсэлт гаргах

Төгсөлт жилд хоёр удаа хавар, намрын улиралд явагдах ба төгсөгчид тавих шаардлагыг бүрэн биелүүлэх боломжтой суралцагч төгсөх хүсэлтээ сургалтын мэдээллийн системээр дамжуулан төгсөх улирлын 6-10 дугаар долоо хоногт багтааж сургалтын албанд гаргана.

Хүндэтгэн үзэх шалтгаанаар хүсэлт гаргах хугацаанаас хоцорсон суралцагчийн төгсөх тухай асуудлыг сургалтын албаны саналыг үндэслэн төгсөлтийн салбар комисс шийдвэрлэж төгсөх боломжтой гэдгийг нь төгсөлтийн үйл явц, ёслолын үйл ажиллагааны талаарх мэдээллийн хамт, эсвэл төгсөхөд дутуу хангагдсан байгаа шаардлагуудын талаар суралцагчид мэдэгдэнэ.

Суралцагч төгсөх хүсэлт гаргасан улиралдаа төгсөж чадаагүй бол төгсөх тухай хүсэлтийг дараагийн улиралд дахин гаргаж болно.

Төгсөлтийн бичиг баримт

Амжилттай сурч, дээд боловсролын бакалавр, магистр, докторын зэргийн болзол хангасан суралцагчийн төгсөлтийн салбар комиссын шийдвэрийг үндэслэн, МУИС-ийн захирлын тушаалаар төгсгөн, мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг болох диплом, энгэрийн тэмдэг олгоно.

Магистр, докторын зэргийн диплом нь МУИС-ийн удирдах зөвлөлийн дарга, МУИС-ийн захирал, хамгаалуулах зөвлөлийн дарга, төгсөлтийн дараах сургуулийн захирлын гарын үсэг, МУИС-ийн тамга тэмдгээр баталгаажих ба (мэргэжлийн магистрын хувьд хамгаалуулах зөвлөлөөр орохгүй тул даргын гарын үсэг шаарлагагүй) дугаар, бүртгэлийн дугаартай байна.

Диплом хавсралттай байх ба хавсралтанд эзэмшсэн үндсэн болон хавсарга мэргэжил, гүнзгийрэн судалсан чиглэл, суралцах хугацаанд амжилттай судалсан хичээлүүд, тэдгээрийн багц цаг, голч дүн ба оноог бичихээс гадна эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрт нийцүүлэн бусад бичиглэлийг хийж болно. Хавсралтыг МУИС-ийн сургалтын нэгдсэн албаны дарга болон сургалтын албаны эрхлэгчийн гарын үсэг, тамга/тэмдгээр баталгаажуулна.

Үндсэн чиглэлээсээ гадна хавсарга мэргэжлээр суралцсан тохиолдолд боловсролын давхар зэрэг, диплом олгохгүй.

Бакалаврын оюутны хувьд суралцах дээд хугацаанд судалбал зохих хичээлийг бүрэн судалсан ч суралцсан хугацааны голч дүн 1.8-аас доош оюутанд МУИС-ийн тухайн мэргэжлийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд заагдсан бүх хичээл судалсаныг гэрчилсэн тусгай бичиг баримт олгож болно.

Магистрант, докторант сургалтын багц цагаа хугацаандаа цуглуулсан боловч магистрын ажил, диссертаци бичих багц цагаа биелүүлж амжаагүй бол МУИС-ийн магистр/докторын сургалт дүүргэсэн тухай захирлын тушаал гаргаж, гэрчилгээ олгоно. Магистрант оюутны сургалтын багц цаг энэхүү гэрчилгээг авснаас хойш 3 жил, докторант оюутны сургалтын багц цаг энэхүү гэрчилгээг авснаас хойш 5 жил хүчинтэй байх ба энэ хугацаанд эрдэм шинжилгээний багц цагаа гүйцээн магистрын ажил, докторын диссертаци бичиж хамгаалах эрхтэй байна.

Төгсөлтийн салбар комисс сургуулийн архивт төгсөж байгаа суралцагчтай холбоотой дараах материалыг бүрдүүлж өгнө. Үүнд:

- Төгсөлтийн салбар комиссын хурлын шийдвэр (загварыг сургалтын төв албанаас гарган мөрдүүлнэ)
- Төгсөгчдөд диплом олгосон бүртгэлийн хуулбар (мэргэжлийн хөтөлбөрөөр)
- Хамгаалуулах зөвлөлийн хуралдааны протокол, тогтоол
- Удирдагчийн тодорхойлолт
- Суралцсан хугацааны тодорхойлолт
- Дипломын хуулбар

- Сурлагын дүнгийн эх хувь (дипломын хавсралт) -1 ширхэг
- Дэлгэрэнгүй анкет (1-р маягт)
- Суралцагчийн үнэмлэх
- Тойрох хуудас

Магистрын ажил, диссертацийг үндэсний номын сан, мэдээллийн технологийн үндэсний парк, сургуулийн номын санд хүлээлгэн өгнө.

Төгсөлтийн баримт бичгийг үрэгдүүлсэн тохиолдолд архивын материалыг үндэслэн зөвхөн дипломыг нөхөн олгох бөгөөд үүнийг тусгай журмаар зохицуулна. Харин комиссын буруутай үйл ажиллагааны улмаас диплом дахин олгох асуудлыг тухайн үед мөрдөгдөж буй дүрэм, журамд нийцүүлэн төгсөлтийн хугацаанд шийдвэрлэнэ.

СУРГАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

Сургалтын төлбөр нь судлах хичээлийн багц цагийн төлбөр, суурь үйлчилгээний төлбөрөөс бүрдэнэ. Сургалтын төлбөрийг суралцагч улирал бүр төлнө.

Суурь үйлчилгээний төлбөр нь МУИС-ийн суралцагчийн суралцах эрхийг хадгалах, нийтлэг үйлчилгээтэй холбоотой зардлаас бүрдэнэ. Энэ нь эрдмийн хамт олон багш профессор, бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн суралцагчидад үзүүлдэг төвлөрсөн үйлчилгээ, номын сан (ном бүрдүүлэлт, олон улсын сэтгүүлийн онлайн эрх, номын сан болон оюутны бие даах төвийн ажилтны цалин хөлс, мэдээлэл, програм хангамж)-ийн үйлчилгээ, сургалтын үйл ажиллагаатай холбогдсон нэгдсэн үйлчилгээ, захиргаа, удирдлагын зардлын тодорхой хувь хэмжээ, оюутны байгууллага, клубын зардал, сургалтын орчинг сайжруулах (хангамж үйлчилгээний алба, үйлчилгээний ажилчдын цалин хөлс, үйл ажиллагааны зардал, МУИС-ийн хөрөнгөөр баригдаж буй барилга байгууламж, оюутны болоод хичээлийн анги танхмийн их ба урсгал засвар, сурах орчны тохижилт, сургалт, судалгаа болоод бусад тоног төхөөрөмжийн элэгдэл), оюутны мэдээллийн үйлчилгээ (оюутны гарын авлага, холбогдох мэдээлэл, мэдээлэл технологийн үйл ажиллагааны төсөв, сургалтын мэдээллийн системийн үйл ажиллагаа, програм хөгжүүлэлт, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл) зэргийг санхүүжүүлнэ.

Багц цагийн төлбөр нь сургалттай холбоотой шууд зардлаас бүрдэнэ. Энэ нь оюутны сурах үйл ажиллагаанд шууд холбоотой сургалтын үйлчилгээ бөгөөд багш профессорууд, салбар сургалтын албадын мэргэжилтэн, зааварлагчдын цалин хөлс, үйл ажиллагааны зардал, хээрийн болон үйлдвэрлэлийн дадлага, сургалтын үйлчилгээний ажилчдын цалин хөлс, хичээл практик, эрдэм шинжилгээний хурал семинарын зардал, оюутны академик үйлчилгээ, оюутны тэтгэлэг, олимпиад, оюутны дунд зохиогддог бүх төрлийн уралдаан тэмцээний зардал, гадаад багш болон багшийн үйл ажиллагаа, хөгжлийг дэмжих зардал, интернэт, сургалтын тоног төхөөрөмж, эд хогшлын зардал зэргийг санхүүжүүлнэ.

Магистрант, докторантын эрдэм шинжилгээний ажлын багц цагийн төлбөр нь лаборатори, судалгааны тоног төхөөрөмжийн зардал, лабораторийн ажилтны зардал, эрдэм шинжилгээний хурал, семинарын зардал, магистрант, докторантын судалгааны ажлын хэлэлцүүлэг, санал, зөвлөмж өгсөн эрдэмтдийн ажлын хөлс зэргийг санхүүжүүлнэ.

Багц цагийн төлбөр нь бүрэлдэхүүн сургууль, салбар, хөтөлбөр, түвшингээрээ өөр өөр байж болно.

Хос, хавсарга хөтөлбөрөөр суралцах оюутан сургалтын багц цагийн төлбөрийг тухайн хос, хавсарга хөтөлбөрийг хэрэгжүүлж буй бүрэлдэхүүн сургуульд, үндсэн мэргэжлийн сургалтын багц цагийн төлбөрийг суурь үйлчилгээний төлбөрийн хамт үндсэн мэргэжлээр суралцаж буй сургуульд төлнө. Хос, хавсарга мэргэжлээр суралцагч нь суурь үйлчилгээний төлбөрийг давхар төлөхгүй.

Нөхцөлтэй элсэн суралцагч нь бакалаврын түвшний хичээл судалбал бакалаврын түвшний багц цагийн төлбөр, магистрын түвшний хичээл судалбал магистрын багц цагийн төлбөр төлнө.

Оюутан магистрын түвшний хичээл судалбал магистрын түвшний багц цагийн төлбөр, магистрант докторын түвшний хичээл судалбал докторын багц цагийн төлбөр төлнө. Магистрант, докторант нь өөр өөрийн хөтөлбөрт заасан хичээлийг хамтдаа судалбал өөр өөрийн түвшний багц цагийн төлбөр төлнө.

Суралцагчийн дүйцүүлсэн багц цагийн төлбөрийг авахгүй.

Суралцагч сургалтын төлбөрөөс гадна төгсөлт, дотуур байр болон бусад нэмэлт үйлчилгээтэй холбоотой төлбөр, хураамжийг тухай бүр төлнө.

Суралцагчаас авах сургалтын үйлчилгээтэй холбоотой төлбөр, хураамжийн хэмжээг санхүү, эдийн засгийн хэлтсээс боловсруулж хичээлийн жил эхлэхээс өмнө МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулан мөрдүүлнэ. Сургалт, үйлчилгээний төлбөрийн дэлгэрэнгүйг МУИС-ийн веб сайтын дүрэм журиын хэсгээс харна уу

СУРГУУЛИАС ОЛГОХ АЛБАН БИЧИГ БАРИМТ, ЛАВЛАГАА

МУИС-ийн бүрэлдэхүүн сургуульд суралцагчаар элсүүлэх тухай захирлын тушаал гарсны дараа элссэн суралцагчдад суралцагчийн үнэмлэхийг үнэ төлбөргүй олгоно. Үнэмлэхээ гэсэн, үрэгдүүлсэн, хулгайд алдсан тохиолдолд зохих төлбөрийг төлж нөхөн авч болно.

Амжилттай сурч, дээд боловсролын бакалавр, магистр, докторын зэргийн болзол хангасан суралцагчийг төгсөхөд тухайн боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх баримт бичиг, энгэрийн тэмдэг олгоно. Дипломын хавсралт дахь дүнгийн жагсаалтад суралцагчийн хангалтгүй судалсан хичээлийн дүнг оруулахгүй.

МУИС-ийн суралцагч мөн болох тухай, суралцаж байх үеийн дүнгийн албан ёсны тодорхойлолтыг суралцагчийн үнэмлэх, Си Си мэдээллийн системд нэвтрэх нууц үгээ ашиглан Түргэн үйлчилгээний цэгийн /ТҮЦ/ машинаас монгол, англи хэлээр үнэт цаасан дээр авч болно. Суралцагчийн болон дүнгийн тодорхойлолтыг тухайн хичээлийн жилд тус бүр 2 удаа үнэ төлбөргүй авах ба үүнээс дээш тоогоор авах тохиолдолд тухай бүр 500 төгрөгийн хураамж төлнө. Уг тодорхойлолт нь тухайн улиралдаа хүчинтэй.

Дүнгийн албан бус тодорхойлолтыг суралцагч Си Си мэдээллийн системээс төлбөргүй авч болно.

Суралцагчийн лавлагаа, тодорхойлолтын загварыг сургалтын нэгдсэн албанаас батлах бөгөөд дараах хугацаанд олгоно.

Бичиг баримтын нэр, төрөл	Олгох алба	Хугацаа
МУИС-ийн суралцагч мөн болох тухай, дүнгийн албан ёсны тодорхойлолт	Сургалтын алба	Ажлын 1 хоногт
	ТҮЦ машин	Тухай бүр
Суралцаж байсан үеийн дүнгийн албан ёсны тодорхойлолт	Сургалтын алба	Ажлын 3 хоногт
Төгссөн тухай тодорхойлолт, дипломын хавсралт дахь дүнгийн албан ёсны магадлагаа	Сургалтын нэгдсэн алба	Англи хэл дээр бол ажлын 3, монгол хэл дээр бол ажлын 1 хоногт
Суралцагчийн үнэмлэх хаяж гээгдүүлсэн тохиолдолд нөхөн авах	Сургалтын нэгдсэн алба	Ажлын 5 хоногт
Диплом нөхөн олгох	Сургалтын нэгдсэн алба	Ажлын 10 хоногт

Албан ёсны бүх бичиг баримтыг олгохдоо зохих хэмжээний хураамж авна

№	Төлбөр хураамжийн нэр	Мөнгөн дүн
1.	Элсэлтийн бүртгэлийн хураамж	
	а/ Гадаад оюутан	
	б/ Бакалаврын бүртгэлийн хураамж	
	в/ Бакалаврын ур чадварын шалгалтын хураамж	
	г/ Бакалаврын бүртгэлийн хураамж /орой, эчнээ/	10000₮
	д/ Магистрант, докторантын бүртгэлийн	25000₮
2.	Бакалаврын түвшинд суралцах эрхийн бичиг буцаалтын төлбөр	Нэг багц цагийн төлбөр
3.	Хичээл сонголтоос хожимдсон бүртгэлийн хураамж	Нэг багц цагийн төлбөр
4.	Оюутны үнэмлэхний үнэ /давтан/	5000₮
5.	Оюутны болон дүнгийн албан тодорхойлолт олгох үйлчилгээний төлбөр /давтан/	500₮
6.	Дүнгийн гомдол барагдуулах үйлчилгээний төлбөр	Нэг багц цагийн төлбөр 1/3
7.	Дахин судлах хичээлийн багц цагийн төлбөр	Тухайн хичээлийн жилийн нэг багц цагийн төлбөр
8.	Дипломын орчуулга, тодорхойлолт /англи хэлээр/	18000₮
9.	Дипломын хавсралтын орчуулга /англи хэлээр/	20000₮
10.	Диплом, дипломын хавсралтын орчуулга, тодорхойлолт /давтан/	15000₮
11.	Диплом нөхөн олгох	90000₮
12.	Дипломын хавсралт нөхөн олгох	50000₮
13.	Диплом, дипломын хавсралт шинээр олгох	Тухайн жилийн худалдан авалтын үнээр
14.	Энгэрийн тэмдэг	
15.	Төгсөлтийн ёслолын хувцас ашиглалтын төлбөр	5000₮
16.	Шилжилтийн төлбөр	Тухайн сургуулийн нэг кредитийн төлбөр
17.	Лавлагаа, тодорхойлолт	5000₮

ОЮУТНЫ ХҮСЭЛТ, САНАЛ ГОМДЛЫГ ХҮЛЭЭН АВАХ, БАРАГДУУЛАХ

Оюутан та сургалт болон бусад үйл ажиллагаатай холбоотой зарлал, зөвлөмж мэдээ, мэдээллийг веб сайт (<http://news.num.edu.mn>), facebook хуудас (МУИС), мобайл аппликашн болон өөрийн суралцаж буй бүрэлдэхүүний сургуулийн зааварлагч нараас авч болно.

Хичээл сонголт, дүнтэй холбоотой асуудлаар хандах бол Сургалтын албаны тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтнээс тодруулна. Таны хүсэлт, санал гомдлын хариу МУИС-ийн төв удирдлага эсвэл Сургалтын нэгдсэн албанаас гарах шаардлагатай бол таны сурч буй сургуулийн сургалтын алба уг асуудлыг дамжуулж хариуг авч оюутанд мэдэгдэнэ.

- ❖ **“R” үнэлгээний хүсэлт гаргах (хичээл дахин судлах) маягт** /Суралцагч судалж, дүгнэгдсэн хичээлээ дахин судлах тохиолдолд, сургалтын албанд хүсэлтээ гаргаж, сургалтын мэдээллийн системд өмнөх үнэлгээг “R” болгож тэмдэглүүлнэ. “R” үнэлгээ тавиулсан тохиолдолд өмнөх дүнг хүчингүй болгох бөгөөд буцаах боломжгүй./ [Татаж авах](#)
- ❖ **Дүнгийн маргаан, гомдол барагдуулах хүсэлтийн маягт** /Суралцагч хичээлийн дүнгийн гомдолтой бол тухайн хичээлийг судалсны дараагийн улирлын эхний 1 сар дотор сургалтын албанд хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлнэ. Шаардлагатай тохиолдолд бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулж шийдвэрлүүлнэ./ [Татаж авах](#)
- ❖ **Хожимдсон бүртгэл хийлгэх хүсэлтийн маягт** / Хүндэтгэн үзэх шалтгаанаар заасан хугацаанд хичээлдээ бүртгүүлж амжаагүй суралцагч тухайн **улирлын эхний 7 хоногт багтан** бүртгүүлэх

боломжтой хичээлд бүртгэлийн хураамж төлж бүртгүүлнэ. Бүртгэлийн хураамж нь тухайн хичээлийн 1 багц цагийн төлбөртэй дүйцэхүйц байна. /

[Татаж авах](#)

- ❖ **Хичээл цуцлуулах хүсэлтийн маягт /** Улирлын хичээл эхэлснээс хойш, сургалтын төлөвлөгөөн дэх тухайн хичээлийн цагийн 30 хувь өнгөрөөгүй байхад баталгаажуулсан хичээлээ цуцлах тохиолдолд хичээлийн багц цагийн төлбөрийн 70 хувийг дараагийн улиралд бүртгүүлэх хичээлийн багц цагийн төлбөрт шилжүүлнэ. Хичээлийн цагийн 30-аас дээш хувь өнгөрсөн бол багц цагийн төлбөрийг буцааж олгохгүй. Аль ч тохиолдолд тухайн улирлын суурь үйлчилгээний төлбөрийг буцааж олгохгүй. /

[Татаж авах](#)

- ❖ **Чөлөөт сонголтын хичээл нэмүүлэх хүсэлтийн маягт /** Суралцагч хичээлийн хуваарийг үндэслэн улирал эхлэхээс өмнөх долоо хоногт хичээлд бүртгүүлэх ба бүртгүүлсэн хичээлийн багц цагийн төлбөр, тухайн улирлын суурь үйлчилгээний төлбөрийг цахим хэлбэрээр төлж, баталгаажуулна./

[Татаж авах](#)

IV БҮЛЭГ. СУРАЛЦАГЧИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР, ҮЙЛЧИЛГЭЭ

САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

МУИС-д амжилттай суралцаж буй авъяаслаг, шилдэг бакалавр, магистр, докторын түвшний суралцагчдын сурч боловсрох, судалгаа шинжилгээний ажил хийж гүйцэтгэх, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, амжилттай суралцаж буй суралцагчийг урамшуулах, шилдэг элсэгчдийг дэмжих зорилгоор тэтгэлэг олгодог бөгөөд сургалтын төлбөр болон амжиргааны зардлыг бүхэлд нь юмуу тодорхой хэсгийг мөнгөн болон бусад хэлбэрээр (сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тодорхой багц цагийн төлбөрөөс чөлөөлөх гэх мэт) санхүүжүүлэхэд буцалтгүй тусламж хэлбэрээр олгогдоно.

МУИС-иас олгох тэтгэлгийн нөхцөл, оюутанд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх, шалгаруулах, тэтгэлгийг олгох гэх мэт үйл ажиллагааг “МУИС-д суралцагчдад тэтгэлэг олгох журам”-аар зохицуулах ба бусад байгууллага, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлгийг олгоход тавигдах шаардлага, болзол зэргийг харгалзан оюутан суралцагчийг тэтгэлэгт нэр дэвшүүлэх, улмаар анхан шатны шалгаруулалт явуулах ажлыг МУИС хариуцан зохион байгуулна.

Суралцагсдад зориулсан дараахи тэтгэлэгүүд байна:

- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай Монгол улсын хуулийн дагуу суралцагчдад олгох үндэсний ба урамшууллын тэтгэлэг
- МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг
- МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг
- Докторын сургалтанд суралцаж буй МУИС-ийн багшид олгох тэтгэлэг
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг
- Гадаад, дотоодын байгууллага, сангийн нэрэмжит тэтгэлэг
- Төгсөгчид, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлэг
- Бусад тэтгэлэгүүд

Дээрх тэтгэлгүүд зарлагдсан даруйд зар, мэдээллийг МУИС-ийн албан ёсны веб сайт <http://www.num.edu.mn/>, <http://news.num.edu.mn/> дээр байршуулж, бүрэлдэхүүн сургуулийн болон холбогдох албаны сошиал медиа сувгаар түгээнэ.

Тэтгэлгийн шалгаруулалтанд нэр дэвших суралцагч нь дараах нийтлэг шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- Улсын болон олон улсын олимпиадад оролцож амжилт гарган тухайн чиглэлээр МУИС-д элссэн элсэгч байх
- Элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээгээр МУИС-д элсэгчдийн авбал зохих оноог авч элссэн байх
- Улиралд дунджаар 12-оос доошгүй багц цагийн хичээл сонгон хоёроос доошгүй улирал амжилттай судалж, суралцах чадвар, идэвхи санаачилгаа илтгэн харуулсан бакалаврын хөтөлбөрийн суралцагч байх
- Хоёроос доошгүй улирал тасралтгүй суралцаж, улиралд дунджаар 6-аас доошгүй багц цагийн хичээл амжилттай судалсан магистрант, докторант байх
- Монгол улсын Засгийн газраас дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгож буй үндэсний болон урамшууллын тэтгэлэгт хамрагдах болзлыг хангасан байх
- Олон улс, улс, бүс нутаг, их дээд сургуулиудын дунд зохиогдсон эрдэм шинжилгээний хурал, олимпиад, спорт, урлагийн наадам, уралдаан тэмцээн, сайн дурын арга хэмжээнд амжилттай оролцож шалгарсан байх

- Докторын сургалтанд гурваас доошгүй улирал тасралтгүй идэвхитэй суралцсан МУИС-ийн үндсэн орон тооны багш байх
- Өмнө нь МУИС-ийн дүрэм, журмыг зөрчиж ямар нэгэн сахилгын шийтгэл, сануулга авч байгаагүй байх
- Энэхүү нийтлэг шаардлагыг хангаагүйгээс тэтгэлэгт хамрагдах боломжгүй суралцагч дараагийн хичээлийн жилд шаардлага хангасан тохиолдолд тэтгэлэгт өрсөлдөх боломжтой.

СУРАЛЦАГЧ СОЛИЛЦООНЫ ХӨТӨЛБӨР

МУИС нь дэлхийн 170 гаруй их дээд сургуультай хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг бөгөөд зарим сургуультай оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлдэг. МУИС-ийн суралцагч оюутан нь БНСУ, Япон Улс, БНХАУ, Тайвань гэсэн Азийн улсуудаас гадна ОХУ, Итали, Испани, Франц, Герман зэрэг Европын их дээд сургуулиудад урт болон богино хугацаагаар тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжтой байдаг. Оюутан солилцооны хөтөлбөрт жилд дунджаар 50 гаруй оюутан хамрагддаг.

Хөтөлбөртэй холбоотой мэдээлэл, зарыг цаг тухай бүрд нь МУИС-ийн албан ёсны веб сайт дээр <http://www.num.edu.mn/>, <http://news.num.edu.mn/> байршуулж, бүрэлдэхүүн сургуулийн болон холбогдох албаны социал медиа сувгаар түгээнэ.

Гадаадын их дээд сургуулийн солилцооны хөтөлбөрт хамрагдах суралцагчид дараах үндсэн шаардлагыг хангасан байна. Үүнд:

- МУИС-ийн 1-3 дугаар түвшний бакалаврын хөтөлбөрийн идэвхитэй суралцагч байх,
- Сурлагын голч дүн 3.0 болон түүнээс дээш байх,
- Тухайн хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангаж байх,
- Англи болон бусад гадаад хэлний мэдлэгтэй байх,
- Үнэнч шударга, зөв төлөвшилтэй, ёс суртахууны хүмүүжил сайтай, элдэв муу зуршилгүй байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

МУИС нь Суралцагчдыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, ажил мэрэгжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах, цагийн болон байнгийн ажлын байрны мэдээллийг түгээж ажилд зүүчлэх, байгууллага хоорондын хамтын ажиллагааны хүрээнд цалинтай болон цалингүй дадлага хийх боломжоор хангах, хөдөлмөрийн яармаг зохион байгуулан суралцагч, төгсөгчдөө ажлын байранд зүүчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Цагийн болон байнгийн ажлын байрны зар, мэдээллийг МУИС-ийн албан ёсны веб сайтаар <http://www.num.edu.mn/>, <http://news.num.edu.mn/> дамжуулан түгээдэг.

МУИС-ийн НОМЫН САН

Байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбаруудад сургалт, эрдэм шинжилгээ явуулахад шаардлагатай бүтээлээр уншигчдын эрэлт хэрэгцээг бүрэн дүүрэн хангах чанартай фондтой, уншигчдын бие даан суралцах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх таатай орчин, сүүлийн үеийн техник технологи бүхий мэдээллийн төвөөр үйлчилгээ явуулдаг. Суралцагчид номын сангаар үйлчлүүлэхдээ суралцагчийн үнэмлэхээ ашиглана.

- ❖ МУИС-ийн профессор багш, ажилтан, суралцагч нарын сургуулийн үнэмлэхийг үндэслэн номын сангийн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлнэ.
- ❖ Төрөлжсөн уншлагын танхимууд нь уншигчдад 1 удаа 5 хүртэлх номыг заалаар олгоно.
- ❖ Багш, ажилтан, докторант, магистрантуудад 1-ээс дээш хувьтай номыг 7-10 хоногийн хугацаатай гэрээр олгох ба дараагийн уншигч тухайн номыг захиалаагүй тохиолдолд хугацааг сунгаж болно.

- ❖ Төрөлжсөн уншлагын танхимуудад байхгүй номыг уншигч Эрдэм шинжилгээний номын фондоос захиална.
- ❖ Фондонд нэг хувь байгаа ном, гар бичмэл, диссертаци, диссертацийн хураангуй, магистрын дипломын ажил, тогтмол хэвлэлийг гэрээр олгохгүй зөвхөн уншлагын танхимаар олгоно.
- ❖ Номын сангийн номзүйч нь интернет каталоги, төрөл бүрийн номзүйн бүртгэл болон лавлагаа мэдээллийн бусад хэрэгслийг ашиглан уншигчдад лавлагаа-номзүйн мэдээлэл өгч үйлчилнэ.
- ❖ Суралцагч нь хичээлийн жилийн төгсгөлд номын сантай номын тооцоо хийх ба сургуулиас шилжсэн, төгссөн тохиолдолд тойрох хуудас зуруулж номын тооцоо хийнэ.
- ❖ Уншигч нь ном, хэвлэлийн бүтээгдэхүүнийг алдаж үрэгдүүлсэн буюу гэмтээсэн тохиолдолд номын санчид мэдэгдэж ижил материалаар төлөх буюу БСШУ-ны Сайдын 2007 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 415 дугаар тушаалаар батлагдсан “Алдагдсан буюу гэмтээсэн ном, хэвлэлийг төлүүлэх журам”-ын дагуу төлж номын санг хохиролгүй болгоно.

Цахим номын сан болон электрон каталоги

МУИС-ийн Номын сангийн <http://catalog.num.edu.mn> хаягаар хандан электрон каталогиос хайлт хийх боломжтой бөгөөд цахим хэлбэрээр байгаа номыг оюутны Sisi нэвтрэх эрхээ ашиглан үзнэ.

Цахим хуудас

Манай номын сангийн веб хуудас <http://library.num.edu.mn>, фэйсбүүк хуудас www.facebook.com/NUMlibrary хаяг руу хандан номын сантай холбогдох мэдээ мэдээлэл, шинэ номын мэдээ зэргийг үзэх мөн онлайн лавлагаа авах, санал хүсэлт, номын татгалзалаа өгөх боломжтой.

Онлайн мэдээллийн сан

МУИС-ийн интернэт сүлжээнд холбогдсон төхөөрөмж ашиглан дэлхийн нэр хүнд бүхий онлайн мэдээллийн системүүдийг ашиглах боломжтой.

- JStor - www.jstor.org
- AGORA - www.fao.org/agora
- ARDI - www.wipo.int/ardi

Номын сангийн байршил, цагийн хуваарь

Алба, хэлтэс	Номын фонд	Байршил	Цагийн хуваарь	Дотуур утас
Төв номын сан				
Нийгмийн шинжлэх ухааны уншлагын танхим	41000	Хич-II, 213 тоот	08 ³⁰ -20 ³⁰	1160
Байгалийн шинжлэх ухааны уншлагын танхим	33000	Хич-II, 307 тоот	08 ³⁰ -20 ³⁰	1161
Гэрээр ном олгох тасаг	30000	Хич-II, 135 тоот	09 ⁰⁰ -19 ⁰⁰	-
Тогтмол хэвлэл, гадаад номын уншлагын танхим	14000	Хич-II, 136 тоот	08 ³⁰ -20 ³⁰	1159
Эрдэм шинжилгээний фонд	139000	Хич-II, 108 тоот	08 ³⁰ -20 ³⁰	1204
Компьютерийн танхим	-	Хич-II, 213 тоот	09 ⁰⁰ -18 ⁰⁰	
Номын сангийн захиргаа	-	Хич-II, 250	09 ⁰⁰ -18 ⁰⁰	1157
Каталоги, лавлагаа номзүйн тасаг	-	Хич-II, 108 тоот	09 ⁰⁰ -18 ⁰⁰	1204
Ном бүрдүүлэн ажиллах тасаг	-	Хич-II, 213 тоот	09 ⁰⁰ -18 ⁰⁰	1205
Ном сэлбэн засах тасаг	-	Хич-II, 136 тоот	09 ⁰⁰ -18 ⁰⁰	-
Мэдээлэл технологийн тасаг	-	Хич-II, 136 тоот	09 ⁰⁰ -18 ⁰⁰	-

Салбар номын сан					
Бизнесийн сургууль		15200	Хич-V, 505 тоот	08 ³⁰ -20 ³⁰	4132
		60000	Хич-VIII	08 ³⁰ -20 ³⁰	7014, 7015, 7016
Хууль зүйн сургууль		26800	Хич-III, 205 тоот	08 ³⁰ -20 ³⁰	3516
Олон улсын харилцаа нийтийн удирдлагын сургууль		7000	Хич-V, 304 тоот	08 ³⁰ -20 ³⁰	5109
Шинжлэх ухааны сургууль	Хүмүүнлэгийн ухаан	13500	Хич-II, 366 тоот	09 ⁰⁰ -19 ⁰⁰	2511, 2714
	Байгалийн ухаан	12800	Хич-VII, 115 тоот	08 ³⁰ -20 ³⁰	2114, 6114
		7400	Хич-I, 105 тоот	08 ³⁰ -20 ³⁰	1312, 1512
	Нийгмийн ухаан	10000	Хич-II, 265 тоот	08 ³⁰ -20 ³⁰	2323
Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургууль		7200	Хич-III 221 тоот	08 ³⁰ -20 ³⁰	3310, 3311

ДОТУУР БАЙР

МУИС нь оюутны зургаан байртай бөгөөд Монгол улсын стандартад нийцсэн өрөөнүүдтэй. цахилгаан, дулаан, интернэт сүлжээгээр хангагдсан. Нэг өрөөнд 2-4 суралцагч амьдардаг. Бүртгэлийг МУИС-ийн мэдээллийн нэгдсэн систем болох СиСи системээр явуулна.

Бүртгүүлэгч нь МУИС-ийн бакалавр, магистр, докторын түвшний идэвхитэй суралцагч байх бөгөөд Шинэ элсэгчийн хувьд Сиси системд нэвтрэх суралцагчийн бүртгэлийн дугаар авсан байх шаардлагатай. суралцагчийн бүртгэлийн дугаараар системд нэвтэрч зааврын дагуу бүртгүүлнэ.

Бүртгүүлэгч системд өөрийн овог нэр, хүйс, оюутны дугаар, сургууль, хөтөлбөр, түвшин, харъяаллын мэдээллийг үнэн зөв оруулж, дотуур байрны давхар, өрөөний сонголтыг /Нэг өрөөнд хэдэн оюутан байрлахаас хамааран төлбөрийн хэмжээ өөр байна/ хийнэ. Нэгэнт хийгдсэн сонголтыг өөрчлөхгүй тул бүртгүүлэгч хариуцлагатай хандах шаардлагатай. . “МУИС-ийн Дотуур байрны журам”-аас дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой. /www.num.edu.mn/

Оюутны байрны мэдээлэл

№	Байр	Хүчин чадал	Байршил	Холбоо барих
1.	Оюутны 1-р байр	260	УБ, СБД, Бага тойруу, 6-р хороо /Хичээлийн 2-р байрны хойно/	77307730-1163
2.	Оюутны 2-р байр	260	УБ, СБД, Бага тойруу, 6-р хороо /Хичээлийн 2-р байрны хойно/	77307730-1164
3.	Оюутны 3-р байр	356	УБ, СБД, 8-р хороо, Оюутны А хотхон	77307730-1165
4.	Оюутны 4-р байр /гадаад оюутны байр/	180	УБ, СБД, 8-р хороо /Дашчойлин хийдийн зүүн талд/	77307730-1166
5.	Оюутны 5-р байр	380	УБ, СБД, 8-р хороо Оюутны А хотхон	77307730-1167
6.	Оюутны 6-р байр	364	УБ, СБД, 8-р хороо /спортын төв ордны зүүн талд/	77307730-1168

ЭМНЭЛЭГ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

МУИС-ийн дэргэдэх эмнэлэг нь суралцагчдад нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламжийг ерөнхий мэргэжлийн болон амны хөндийн эрүүл ахуйн чиглэлээр жигд хүртээмж, чанартай үзүүлэхийг эрхэмлэн ажилладаг. ЭКГ, УВЧ, ИСКРА, утлагын аппарат бүхий эмчилгээний кабинет,

2 суудал бүхий солюкс шүдний кабинеттай ба Солонгос, Япон, Герман зэрэг орны шүдний эм бэлдмэл, яаралтай болон зайлшгүй шаардлагатай эм тариа бэлдмэлээр хангагдсан байдаг. суралцагчдад ерөнхий эмчийн үзлэг, эмчилгээ үнэ төлбөргүй ба шүдний эмчилгээ 20%-ийн хөнгөлөлттэйгөөр үйлчилдэг бөгөөд эмнэлэг нь оюутны байранд амьдардаг суралцагчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор ОУ-ын болон сайн дурын байгууллагатай хамтран эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг МУИС-ийн суралцагчдын асуудал хариуцсан захиргааны нэгжтэй хамтран зохион байгуулдаг.

Тус эмнэлэгийн үйл ажиллагаа, хүчин чадлын хувьд:

- Өдөртөө 20-25 хүнд дотрын эмчийн үзлэг, оношилгоо, эмчилгээ, зөвөлгөө өгөх
- Бүх төрлийн тарилга хийх
- Шарх, шархлааны боолт хийх, цэвэрлэх
- Физик эмчилгээ, аппаратаар шарлага хийх /УВЧ, Искра, утлага/
- Шүдний оношилгоо, эмчилгээ, шүд авах 20-25 хүнд үйлчлэх
- Хиймэл шүд /авагддаг авагддаггүй/

НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

- Нийтийн тээврээр үнэгүй зорчих эрх олгох үйл ажиллагааны ерөнхий зохион байгуулалт
- Баруун таван аймгийн суралцагчдад замын зардлыг олгох үйл ажиллагааг зохион байгуулах
- Суралцагчийг Нийгмийн, гэнэтийн ослын даатгал болон ЭМД-д хамруулах
- “Оюутан цэрэг” хөтөлбөрт хамруулах /Хөтөлбөрийн зарлагдсан даруйд мэдээллийг боловсруулан зар түгээж, бүртгэл хийх, бусад зохион байгуулалтын ажил/
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан үйл ажиллагаа зэрэг суралцагчдад хүргэх нийгмийн халамж, үйлчилгээг Оюутны асуудал хариуцсан нэгжээр дамжуулан зохион байгуулдаг.

УРЛАГ, СОЁЛ, ОЛОН НИЙТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Суралцагчдын дунд спорт болон урлаг соёлын уралдаан, тэмцээн зохион байгуулах
- Сургуулийн нэрийн өмнөөс олон улсын болон улсын чанартай уралдаан тэмцээнд бэлтгэх, оролцуулах
- Суралцагчдад зориулсан чөлөөт цагийн дугуйлан, сайн дурын үйл ажиллагааг дэмжин, үйл ажиллагаа явуулах нөхцлөөр хангах
- Урлаг, соёл, үйлчилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж, суралцагчдыг үзвэр үйлчилгээнд хөнгөлөлттэй үнээр хамруулах
- Оюутны өөрөө удирдах байгууллагатай хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хамтран ажилладаг.
- Сонирхлоороо нэгдсэн оюутны клубуудтэй үр дүнтэй хамтран ажиллаж, үйл ажиллагааг дэмжих зэргээр суралцагчдын нийгмийн амьдрал, төлөвшилд зориулсан үйл ажиллагааг дэмжиж ажилладаг.

Хууль зүйн зөвлөгөө өгөх төв

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн “Хууль зүйн клиник” хичээлийн хүрээнд суралцагчдад нь эрүү, иргэн, захиргааны эрх зүйн багт хуваагдан, хуваарийн дагуу сэдэвчилсэн төлөвлөгөөт хичээлд хамрагдан хичээлийн бус цагаар “Хууль зүйн зөвлөгөө өгөх төв” болон www.Mongolianlaws.com цахим хуудсаар дамжуулан иргэдэд зөвлөгөө өгдөг.

Тус төв нь хууль, эрх зүйн тодорхой маргаантай, мэргэжлийн зөвлөгөө шаардлагатай асуудлаар төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөх зорилготой бөгөөд оюутан та ч бас хандаж болно.

“Хууль зүйн зөвлөгөө өгөх төв” нь суралцагчдад дараах хэлбэрээр туслалцаа үзүүлнэ.

- Эрх зүйн асуудлаар зөвлөгөө өгөх,
- Хууль тогтоомжийн лавлагаа өгөх,
- Нэхэмжлэл, өргөдөл, гомдол, гэрээний төсөл зэрэг баримт бичгийг боловсруулж өгөх,
- Шүүхийн өмнөх шатанд үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах,
- Шүүхэд төлөөлөх гэх мэт

Сэтгэл зүйн оношилгоо, сургалт, судалгааны төв

Тус төвд сэтгэлзүйчийн нарийн мэргэжлийн диплом бүхий эрдмийн зэрэг цолтой, мэргэжлээрээ дагнан ажилласан олон жилийн туршлагатай, гадаад дотоодын сургалтанд хамрагдсан, их, дээд сургуулиудад олон жил багшилсан мэргэжилтнүүд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг:

- Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх,
- Сэтгэл засал хийх,
- Сэтгэл зүйн оношлогоо хийх,
- Стресс тайлах,
- Сэтгэл зүйн боловсрол, сэтгэцийн эрүүл мэндийн сургалт явуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Мөн сэтгэл зүйн оношилгоог компьютерийн болон энгийн аргаар дараах чиглэлээр хийдэг. Үүнд:

- Харилцааны үр чадварын төвшинг тогтоох,
- Зан төлөв, авир араншингийн онцлогийг тодорхойлох,
- Оюуны коэффициентийг тогтоох,
- Авъяас чадварын чиглэлийг гаргах,
- Мэргэжлийн чиг баримжаа, мэргэжил сонголтын чиглэлийг тогтоох,
- Стрессийн төвшинг илрүүлэх, түүний шалтгааныг тогтоох,
- Эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийх.

**V БҮЛЭГ. ШААРДЛАГАТАЙ УТАС БОЛОН ХИЧЭЭЛИЙН БАЙР,
ӨРӨӨНИЙ ДУГААР, БАЙРШИЛ
МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН УТАС, ӨРӨӨНИЙ ДУГААР**

№	Мэргэжилтэн	Хичээлийн байр, өрөөний дугаар	77307730 - дотуур утасны дугаар
СУРГАЛТЫН НЭГДСЭН АЛБА			
1	Мэргэжилтэн /магистр, доктор/	I байр 203 тоот	1121
2	Ахлах мэргэжилтэн /сургалт/	I байр 203 тоот	1122
3	Мэргэжилтэн /элсэлт, төгсөлт/	I байр 203 тоот	1123
4	Ахлах мэргэжилтэн /хөтөлбөр/	I байр 203 тоот	1124
5	Мэргэжилтэн /сургалтын технологи/	I байр 203 тоот	1125
6	Мэргэжилтэн /оюутны бүртгэл/	I байр 203 тоот	1126
7	Мэргэжилтэн /хөтөлбөр/	I байр 203 тоот	1127
8	Мэргэжилтэн /соёл, олон нийтийн асуудал/	I байр 206 тоот	1128
9	Мэргэжилтэн /мэдээлэл/	I байр 203 тоот	1129
10	Мэргэжилтэн/гадаад оюутан, оюутан солилцоо/	I байр 219 тоот	1139
11	Ахлах мэргэжилтэн /оюутанд үйлчлэл/	I байр 219 тоот	1143
12	Мэргэжилтэн /ЦСТ - ийн сургалт/	I байр 219 тоот	1144
13	Цахим төв	III байр 122 тоот	3404
14	Цахим төв	III байр 122 тоот	3404
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ			
1	Захирлын туслах	II байр 330 тоот	2101
2	Элсэлт, төгсөлт хариуцсан мэргэжилтэн	II байр 216 тоот	2103, 2105, 2108, 2109, 2119
3	Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	II байр 216 тоот	2104, 2117
4	Оюутны бүртгэл хариуцсан мэргэжилтэн	II байр 216 тоот	2106, 2107, 2115
5	Гадаад оюутан хариуцсан мэргэжилтэн	II байр 216 тоот	2106
6	Сургалтын технологи хариуцсан мэргэжилтэн	II байр 300 тоот	2110, 2111, 2118, 2116
7	Сургалтын албаны зааварлагч	II байр 200 тоот	2112, 2113, 2113, 2114
ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ			
1	Захирлын туслах	III байр 211 тоот	3101
2	Элсэлт, төгсөлт хариуцсан мэргэжилтэн	III байр 212 тоот	3108
3	Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	III байр 212 тоот	3104, 3105
4	Оюутны бүртгэл хариуцсан мэргэжилтэн	III байр 212 тоот	3103
5	Сургалтын технологи хариуцсан мэргэжилтэн	III байр 212 тоот	3109
6	Сургалтын албаны зааварлагч	III байр 212 тоот	3106, 3107
БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ			
1	Захирлын туслах	VIII байр 205 тоот	4101
2	Элсэлт, төгсөлт хариуцсан мэргэжилтэн	IV байр 203 тоот	4106
3	Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	IV байр 219 тоот	4105
4	Оюутны бүртгэл хариуцсан мэргэжилтэн	IV байр 203 тоот	4103
5	Сургалтын технологи хариуцсан мэргэжилтэн	IV байр 203 тоот	4103
6	Сургалтын албаны зааварлагч	IV байр 219 тоот	4104
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ			
1	Захирлын туслах	IIIб байр 205 тоот	3502. 329680
2	Элсэлт, төгсөлт хариуцсан мэргэжилтэн	IIIб байр 206 тоот	3503
3	Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	IIIб байр 206 тоот	3518

4	Оюутны бүртгэл хариуцсан мэргэжилтэн	IIIб байр 206 тоот	3518
5	Сургалтын технологи хариуцсан мэргэжилтэн	IIIб байр 206 тоот	3503
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ			
1	Захирлын туслах	V байр 204 тоот	5101
2	Элсэлт, төгсөлт хариуцсан мэргэжилтэн	V байр 2016 тоот	5107
3	Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	V байр 2016 тоот	5107
4	Оюутны бүртгэл хариуцсан мэргэжилтэн	V байр 2016 тоот	5107
5	Сургалтын технологи хариуцсан мэргэжилтэн	V байр 2016 тоот	5103
6	Сургалтын албаны зааварлагч	V байр 2016 тоот	5103
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЛБА			
1	Хэрэглэгчдэд үйлчлэх мэргэжилтэн	II байр өргөтгөлийн 501, 503 тоот	1153, 1154

- * **Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн** /Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, мэргэжил сонголт, тандалттай холбоотой асуудлаар мэдээлэл, зөвөлгөөгөөр хангах./
- * **Элсэлт, төгсөлт хариуцсан мэргэжилтэн** / Бакалавр, магистр, докторын зэргийн өдөр, орой, эчнээ хэлбэрийн сургууль/хөтөлбөрт элсэлт, төгсөлт, оюутныг шилжүүлэн суралцуулах үйл ажиллагааг зохих хууль тогтоомж, дүрэм журам, тушаал, шийдвэрийн дагуу зохион байгуулах, мэдээлэл, зөвөлгөөгөөр хангах./
- * **Бүртгэл хариуцсан мэргэжилтэн** /Шинэ суралцагчийн бүртгэл, улирлын чөлөө, үргэлжлүүлэн суралцуулах, сургуулиас хасах, сургалтын үйл ажиллганы явц аливаа дүнгийн гомдол, МУИС-ийн сургалтын журмын дагуу шийдвэрлэх, суралцагчийн үнэмлэх хэвлэх, олгох, заавар зөвөлгөөгөөр хангах./
- * **Сургалтын технологи хариуцсан мэргэжилтэн** /Сургалтын мэдээллийн систем дэх багшийн, хичээлийн, анги танхимын мэдээллийг хянаж, шаардлагатай мэдээллийг оруулах, хичээлийн болон шалгалтын хуваарийг болвсруулан сургалтын мэдээллийн системд оруулж мөрдөхөд нь хяналт тавина./
- * **Сургалтын албаны зааварлагч** /Суралцагчийн санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлж, хариу өгөх, Дотуур байр, эрүүл мэндийн үзлэг, даатгал, аливаа суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаанд суралцагчдийг хамруулах, мэдээлэл, зөвөлгөөгөөр хангах./

ХИЧЭЭЛИЙН БАЙРНЫ ПЛАН ЗУРАГ

Хичээлийн I байр

1-р давхар

